



ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ЯПОН УЛСЫН ЖИШЭЭ



ТӨРИЙН ӨМЧИЙН
УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ
ЯПОН УЛСЫН ЖИШЭЭ

Ганхуягийн Давааням

Улаанбаатар хот
2021 он

ННА 67.3
ДАА 340.009
Б-121



ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ЯПОН УЛСЫН ЖИШЭЭ

Судалгааг хийж гүйцэтгэсэн

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш,
хууль зүйн доктор Г.Давааням

Тус тайлангийн үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж нь судлаачийн дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9678-5-7

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн нэг гол хэсэг нь бүх ард түмний мэдэлд байх байгалийн баялгийг ашиглах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, одоо ба ирээдүй үеийн нийтлэг ашиг сонирхлын төлөө олон нийтийн хяналтын дор зөв, оновчтой удирдаж, хүн амын амьдралын нөхцөлийг сайжруулахад үр дүнтэй төлөвлөн ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн үзэл баримтлалууд юм. Шинээр Үндсэн хуульд суусан дээрх үзэл баримтлалыг бүрэн хэрэгжүүлж, байгалийн баялгийг урт хугацааны алсын хараа, бодлогоор удирдан иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөлгүйгээр ашиглаж нийгэм, эдийн засаг, байгаль орчны тэнцвэрийг хангах оновчтой тогтолцоог салбарын хуулиудаар бий болгох нь томоохон сорилт болж байна. Тэрчлэн хүн бүрт хүртээмжтэй хөгжил дэвшил болгон хувиргахад Үндсэн хуульд шинээр орсон дээрх зарчим, үзэл санааг хамгийн зөв утгаар утгажуулан тайлбарлаж, хэрэгжүүлэх нь юу юунаас чухал байна.

Иймээс ННФ нь эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэх бодлогын хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулах зорилгоор төрийн нийтийн өмч, түүнийг зөв зохистой удирдах, ялангуяа төрийн нийтийн өмчийн байгалийн баялгийг ашиглахад баримтлах журам, үр өгөөжийг оновчтой зарцуулах, тэгш шударга хуваарилах арга замыг тодорхойлоход чиглэсэн багц судалгааны ажлыг дэмжин хийж гүйцэтгэлээ. Уг ажлын хүрээнд 3 судалгаа хийгдсэн бөгөөд тэдгээрийг цувралаар Та бүхэнд танилцуулж байгаадаа баяртай байна.

Цувралын энэ удаагийн дугаараар судлаач Г.Даваанямын “Төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт: Япон Улсын жишээ” судалгааны тайланг хүргэж байна. Энэхүү тайланд тухайн хөрөнгийн зориулалт, онцлог шинжээс хамааран түүний удирдлага, бүртгэл,

хяналтын тухайлсан дэглэмийг тогтоон мөрдөж буй Япон Улсын туршлагад тулгуурлан манайд түгээмэл гарах болсон төрийн өмчийг зориулалтын бусаар, үр ашиггүй зарцуулах явдлыг залруулахад ач холбогдолтой санаануудыг дэвшүүлжээ. Бүх төрлийн төрийн өмчийн удирдлагад нийтлэг хамаарах үндсэн зарчмыг тогтоосон суурь хуулийг батлахаас гадна төрийн өмчийн хөрөнгийн ангиллыг зориулалтыг нь харгалзан шинэчлэн тогтоож, тэрхүү ангилалд тохирсон тусгайлсан хяналт, бүртгэл, тайлагнал, зөвшөөрлийн тогтолцоог бий болгохын ач холбогдлыг дурджээ. Тэрчлэн манай улсын хувьд төрийн өмчийн ашиглалт, зарцуулалтын зүй зохистой байдлыг хангах олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоход тухайн төрлийн хөрөнгийн үнэ цэнэ, удирдлага, ашиглалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг шат шатандаа тайлагнан нийтэд мэдээлдэг Япон Улсын туршлагаас санаа авууштай байна.

Судалгааг хийж гүйцэтгэсэн МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн доктор Г Давааням болон үнэтэй санал шүүмж өгсөн ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг нарт талархал илэрхийлье.

Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

ОРШИЛ	7
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЯПОН УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ	10
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЯПОН УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ	11
2.1 Төрийн өмчийн тухай хуульд хамаарах өмч	11
2.1.1 Төрийн өмчийн тухай ойлголт, түүний хүрээ	11
2.1.2 Төрийн өмчийн ангилал	13
2.2 Төрийн өмчийн өнөөгийн байдал	15
2.2.1 Захиргааны өмчийн өнөөгийн байдал	16
2.2.2 Ердийн өмчийн өнөөгийн байдал	17
2.3 Төрийн өмчийг удирдах этгээд	26
2.3.1 Төрийн өмчийн нэгдсэн удирдлага	26
2.3.2 Төрийн өмчийн тухайлсан удирдлага	27
2.4 Төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах	28
2.4.1 Захиргааны өмчийг удирдах, захиран зарцуулах	28
2.4.2 Ердийн өмчийг удирдах, захиран зарцуулах	30
2.4.3 Ердийн өмчийг захиран зарцуулах хэлбэрүүд	31
2.5 Төрийн өмчийн харьяаллыг өөрчлөх	37
2.6 Төрийн өмчид нэвтрэх, хил хязгаарыг тогтоох	37
2.6.1 Төрийн өмчид нэвтрэх	37
2.6.2 Хил хязгаарыг тогтоох	38
2.7 Ил тод байдал, тайлагнал	38
2.7.1 Төрийн өмчийн журнал	38
2.7.2 Төрийн өмчийн өөрчлөлтийн тайлан	40
2.7.3 Төрийн өмчийн үнэлгээний талаар урьдчилсан таамаглалын тайлан	41

2.7.4 Төрийн өмчийг хариу төлбөргүй түрээслүүлсэн байдлын тайлан	42
2.7.5 Ил тод байдал	42

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН ӨМЧИЙН ШААРДАХ
ЭРХИЙГ УДИРДАХ ТУХАЙ ХУУЛЬ** 47

3.1. Төрийн өмчийн шаардах эрхийн тухай ойлголт	47
3.2. Шаардах эрхийг удирдах этгээд	48
3.2.1 Шаардах эрхийн нэгдсэн удирдлага	48
3.2.2 Шаардах эрхийн тухайлсан удирдлага	48
3.3. Тайлагнал	48

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭД ЗҮЙЛСИЙН УДИРДЛАГЫН
ТУХАЙ ХУУЛЬ** 50

4.1. Эд зүйлсийн тухай ойлголт, түүний хүрээ	51
4.2. Эд зүйлсийн ангилал	51
4.3. Эд зүйлсийг удирдах этгээд	52
4.3.1 Эд зүйлсийн нэгдсэн удирдлага	53
4.3.2 Эд зүйлсийн тухайлсан удирдлага	53
4.4. Эд зүйлсийг удирдах	54
4.4.1 Олж авах, ашиглалтад өгөх	54
4.4.2 Хадгалах	55
4.4.3 Захиран зарцуулах	55
4.5. Тайлагнал	56

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 57

АШИГЛАСАН МАТЕРИАЛ 62

ОРШИЛ

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн” гэдэг заалт байсан. Харин 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 6.2 дахь “төрийн өмч” гэсэн өмнөх томъёоллыг “төрийн нийтийн өмч” гэж өөрчлөн хуульчилсан билээ.

Уг нэр томъёоны “цаад агуулга нь нэгдүгээрт, төрийн нийтийн өмчийг буюу иргэдэд өмчлүүлснээс бусад газар, байгалийн баялгийг эзэмших, захиран зарцуулах бүрэн эрхийг Монгол Улсын ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурал (УИХ) бодлогын хувьд шийдвэрлэнэ. Шаардлагатай бол Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу иргэдийн санаа бодлыг асууж шийдэж болно ... хоёрдугаарт, “нийтийн” гэдэгт ямар санаа байна гэхээр Монголын ард түмний нийтлэг ашиг сонирхол буюу нийтийн ашиг сонирхлын үүднээс тэр газар, байгалийн баялгийн хувь заяаг шийдвэрлэнэ”¹ гэжээ.

Энэхүү Үндсэн хууль дахь “төрийн өмч” гэсэн нэр томъёог “төрийн нийтийн өмч” болгон өөрчлөх болсон үйл явцын ард төрийн нийтийн өмчийн удирдлага, эрх зүйн зохицуулалт өнөөг хүртэл хангалтгүй байснаас үүдэн төрийн нийтийн өмчийг хувийн ашиг сонирхлын үүднээс захиран зарцуулах, үр ашиггүй болгох “*tragedy of the commons*” (цаашид, нийтийн өмчийн эмгэнэл гэх) асуудал өргөн хүрээнд үүссэнтэй холбоотой байж болох юм.

Түүнчлэн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг дагалдан ердийн хуулийн шинэчлэл хараахан хийгдээгүйн улмаас төрийн өмчийн харилцааг зохицуулж буй холбогдох хууль тогтоомж Үндсэн хуультай зөрчилдөх асуудал үүсэж байна. Тухайлбал, 1996 оны 5 дугаар сард батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн

¹ О.Мөнхсайхан, ikon.mn-д өгсөн ярилцлага 2020.06.19 [<https://ikon.mn/n/1x1c>]

4.4-т “Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн (Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн), бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно” гэсэн заалтыг дурдаж болно. Улмаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн шинэчлэхээс гадна “нийтийн өмчийн эмгэнэл”-ийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд төрийн бүхий л төрлийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Төрийн нийтийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт нь Монгол төдийгүй бусад улсын хувьд ч чухлаар тавигдаж байна. Өндөр хөгжилтэй улсуудын дундаас Америк, Япон, Герман, Франц зэрэг улсууд² төрийн өмчийн талаарх эрх зүйн зохицуулалтыг сайтар хөгжүүлсэн байна. Эдгээрээс Япон Улс нь 1918 онд Төрийн өмчийн тухай хуулиа баталсан бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэх хугацаанд хуримтлуулсан туршлагад тулгуурлан 1948 оноос эхлэн төрийн өмчийн талаарх багц хуулийг боловсруулан гаргажээ.

Япон Улсын төр нь бусад улсын адилаар газар, барилга зэрэг үл хөдлөх хөрөнгө, бэлэн мөнгө, ширээ сандал, машин, усан онгоц зэрэг хөдлөх хөрөнгө, газрын болон газрын хэвлийн баялгийн үр шимийг хүртэх эрх, зээлийн төлбөр, бусад төрлийн авлагыг агуулсан шаардах эрх, оюуны өмч зэрэг олон төрлийн хөрөнгийг өмчилнө. Хэдий тийм боловч төрийн өмчид хамаарах хөрөнгө нь зориулалтын хувьд өөр хоорондоо ялгаатай байхаас гадна хөрөнгө тус бүрийн онцлогоос шалтгаалан түүнийг удирдах, захиран зарцуулах харилцааг ялгамжтай байдлаар авч үзэх шаардлага зүй ёсоор тавигддаг байна.

Япон Улс нь төрийн өмчийг удирдах хүрээнд төрийн өмчийн хөрөнгийн зориулалт, түүний шинж чанар, онцлогт нийцүүлэн өөр хоорондоо ялгаатай эрх зүйн зохицуулалт бий болгохын эрмэлзжээ. 1948 онд батлагдсан “Төрийн өмчийн тухай хууль” нь төрийн өмчийн харилцааг зохицуулсан гол хууль бөгөөд үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, түүний нэг хэсэг болох үнэт цаас зэрэг тодорхой төрлийн хөрөнгийг удирдах харилцаанд үйлчилдэг.

² Англи Улсын хувьд бичмэл хуулийн зохицуулалт байхгүйгээс гадна төрийн нийтийн өмчийн хүрээнд хааны гэр бүлийн хөрөнгөөс өөр ангиллыг бий болгоогүй.

Харин төрийн өмчийн тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй бусад хөдлөх хөрөнгийн хувьд бие даасан хөрөнгийн удирдлагын механизм үйлчилнэ. Тухайлбал, бэлэн мөнгөний хувьд Төсвийн орлого, зарлагын бүртгэлийн тухай, төрийн өмчийн шаардах эрхийн хувьд Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай, ширээ сандал зэрэг хөдлөх хөрөнгийн хувьд Эд зүйлсийг удирдлагын тухай хуулиуд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Энэ судалгааны хүрээнд Японы Улсын төрийн өмчийн харилцаа (бэлэн мөнгөнөөс бусад)-г зохицуулсан дараах голлох гурван хуульд анхаарал хандуулан авч үзлээ.

- 1) Төрийн өмчийн тухай хуулийн хууль (1948)
- 2) Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай хууль (1955)
- 3) Эд зүйлсийн удирдлагын тухай хууль (1956)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЯПОН УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Япон Улс нь 1890 онд Эзэн хааны зарлигаар Төрийн өмчийн тухай журмыг анх батлан гаргасан байдаг³. Хэдий тийм боловч уг журам нь тодорхой төрлийн төрийн өмчийн хөрөнгөд үйлчилж байснаас бус төрийн өмчийн удирдлагын нэгдсэн тогтолцоо тэр үед байгаагүй. Иймээс төрийн өмчийн нэгдсэн удирдлагын тогтолцоо чухлаар тавигдах болжээ.

Улмаар 1918 онд төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг бий болгох үүднээс Төрийн өмчийн тухай хуулийг батлан гаргажээ. Энэ нь төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг тогтоосноос гадна төрийн өмчийн хөрөнгийг олж авах, хадгалах, удирдах, захиран зарцуулахтай холбоотой бүхий л харилцааг зохицуулахыг эрмэлзсэн анхны хууль байсан. Гэвч уг хууль болон 1890 онд батлагдсан журмын дагуу төрийн өмчид хамаарч ирсэн зам, гол горхи, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн талбай зэрэг нийтийн шинжтэй хөрөнгийн ил тод байдлыг хангах шаардлага тавигдсан.

Тэрчлэн хөрөнгийн ангилал, зориулалтыг өөрчлөх тохиолдолд ард түмний төлөөлөл болох Парламентаар хэлэлцүүлэх шаардлагыг тавих болсон. Улмаар төрийн өмчийн ангилал, түүний удирдлагын харилцааг боловсронгуй болгох үүднээс 1948 онд Төрийн өмчийн тухай хуулийг баталж гаргасан байна.

Мөн Төрийн өмчийн тухай хуулийн гадна үлдсэн төрийн зарим өмчийг зохицуулах зорилгоор төрийн өмчийн шаардах эрхийн харилцаанд хамаарах Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай хуулийг 1955 онд, ширээ сандал, компьютер зэрэг зарим хөдлөх хөрөнгийн харилцаанд хамаарах Эд зүйлсийн удирдлагын тухай хуулийг 1956 онд тус тус батлан гаргажээ.

³ 官有財産管理規則（明治23年勅令第275号）。

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЯПОН УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Өнөөгийн байдлаар 1948 онд батлагдсан Төрийн өмчийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Уг хууль нь төрийн өмчийг удирдах (олж авах, хадгалах), захиран зарцуулах харилцааг зохицуулсан суурь хууль бөгөөд дараах бүтэцтэй. Үүнд:

1948 оны Төрийн өмчийн тухай хуулийн бүтэц

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл

Бүлэг 2. Удирдах, захиран зарцуулах этгээд

Бүлэг 3. Удирдах, захиран зарцуулах

Хэсэг 1. Нийтлэг үндэслэл

Хэсэг 2. Захиргааны өмч

Хэсэг 3. Ердийн өмч

Бүлэг 4. Төрийн өмчийн хөрөнгөд шалгалт оруулах,
хил хязгаарыг тогтоох

Бүлэг 5. Журнал, тайлагнал

Бүлэг 6. Дагалдах журам

2.1. Төрийн өмчийн тухай хуульд хамаарах өмч

2.1.1. Төрийн өмчийн тухай ойлголт, түүний хүрээ


Төрийн өмчийн тухай хууль нь төрийн өмчийг зохицуулсан суурь хууль боловч уг хуулийн үйлчлэх хүрээ нь хязгаарлагдмал шинжтэй. Өөрөөр хэлбэл, уг хууль нь зөвхөн дараах төрийн өмчийн хөрөнгийн хүрээнд үйлчилнэ⁴. Үүнд:

⁴ 国有財産法2条。

- Үл хөдлөх хөрөнгө;
- Усан онгоц, усны хөвөгч (*biyo*), хөвөгч гүүр, нисэх онгоц;
- Газар ашиглах эрх, сервитут эрх, ашигт малтмалын лиценз болон бусад төстэй эрх;
- Патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг болон бусад эрх;
- Хувьцаа, хувьцаанд хөрвөх эрх, өрийн хэрэгсэл, хөрөнгө итгэмжлэлийн ашиг хүртэх эрх болон бусад үнэт цаас, хөрөнгө оруулалтад суурилсан эрх.

Төрийн өмчийн тухай хууль нь бүх төрлийн төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, газрын эрх, оюуны өмч, үнэт цаасны эрхэд үйлчилнэ хэмээн ойлгож болно (*График 1*).

График 1. Төрийн өмчийн тухай хуулийн үйлчлэх хүрээ, хөрөнгийн ангилал



Харин зарим хөдлөх хөрөнгө болон шаардах эрхийг удирдах харилцаанд үйлчлэхээргүй байна. Өөрөөр хэлбэл, Төрийн өмчийн тухай хууль нь төрийн өмчийн бэлэн мөнгө, шаардах эрх, зарим хөдлөх хөрөнгө зэрэг бие даасан хуулиар тусгайлан зохицуулах шаардлага бүхий төрийн өмчийн хөрөнгөд хамаарахгүй юм.

Мөн Япон Улс нь байгалийн баялгийг төрийн өмчид тооцдоггүй ажээ. Харин байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн ашигт малтмалын лиценз нь төрийн ердийн өмчит хамаарна.

2.1.2. Төрийн өмчийн ангилал

Төрийн өмчийн тухай хуульд төрийн өмчийн ангиллыг дараах байдлаар хуульчлан тогтоосон байна. Үүнд:

- 1) Захиргааны өмч (行政財産)
- 2) Ердийн өмч (普通財産)

“Захиргааны өмч” гэж захиргааны үйл ажиллагаа явуулах хүрээнд зайлшгүй шаардлагатай хөрөнгийг хэлнэ. Энэ төрлийн өмчийн хөрөнгөд төрийн байгууллагын барилга, нийтийн зориулалтай зам, цэцэрлэгт хүрээлэнгээс эхлээд төрийн өмчийн ой мод зэрэг хамаарна.

Захиргааны өмчийг дараах байдлаар дөрөв ангилна. Үүнд:

- 1) Албаны өмч (公用財産)

“Албаны өмч” гэж төрийн албан үүрэг, үйл ажиллагаа эсхүл албан хаагчийн байрлахад зориулсан хөрөнгийг хэлнэ. Үүнд төрийн байгууллагын барилга, шоронгийн барилга, онгоцны буудал, зэвсэгт хүчний барилга, төрийн өмчийн хоноглох болон орон сууцны барилга зэрэг хамаарна.

- 2) Нийтийн өмч (公共用財産)

“Нийтийн өмч” гэж төрөөс шууд нийтийн хэрэгцээнд зориулсан хөрөнгийг хэлнэ. Үүнд төрийн өмчийн зам, гол горхи, боомт, цэцэрлэгт хүрээлэн зэрэг хамаарна. Энэ төрлийн хөрөнгө нь нийтийн зориулалтай тул түүний ангиллыг өөрчлөх, зориулалтыг өөрчлөх тохиолдолд Парламентаар хэлэлцүүлэх хатуу шаардлагыг тавьж өгсөн.

- 3) Хааны гэр бүлийн өмч (皇室用財産)

“Хааны гэр бүлийн өмч” гэж төрөөс хааны гэр бүлийн хэрэгцээнд зориулж тогтоож өгсөн хөрөнгийг хэлнэ. Үүнд хааны ордон, хааны зуслан зэрэг хамаарна.

- 4) Аж ахуйн зориулалттай өмч (企業用財産)

“Аж ахуйн зориулалттай өмч” гэж төрийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл аж ахуйн үйл ажиллагаа явуулахаар албан хаагчид олгосон хөрөнгийг хэлнэ. Үүнд одоогийн хуулиар гагцхүү ойн аж ахуйн зориулалттай төрийн өмчийн ой хамаарна.

Өмнө нь Үндэсний хэвлэлийн агентлаг (*National Printing Bureau*), Төрийн өмчийн төмөр зам (*Japanese National Railways*), Цахилгаан утасны нийтийн эзэмшлийн компани (*Nippon Telegraph and Telephone Public Corporation*), Япон шуудан (*Japan Post*) зэрэг төрийн аж ахуйн зориулалтай олон өмчийн хэлбэр оршиж байсан боловч одоо бүгд хувьчлагджээ.

Харин “ердийн өмч” гэж захиргааны өмчийн ангилалд хамаарахгүй бусад төрийн өмчийн хөрөнгийн ерөнхийлсөн ангилал бөгөөд захиргааны үйл ажиллагаанд шууд ашиглагдахгүй хөрөнгийг хэлнэ. Ердийн өмчид хамаарах хөрөнгийг дараах байдлаар хоёр ангилж болно. Үүнд:

- захиргааны өмчтэй төстэй шинж чанарыг агуулах өмчийн хөрөнгө;
- бусад хөрөнгө.

Захиргааны өмчтэй төстэй шинж чанар бүхий хөрөнгөд төрийн бодлогын хүрээнд хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт, Япон болон АНУ хооронд байгуулсан гэрээний дагуу Японд байршиж буй АНУ-ын цэргийн баазад олгосон баазын байгууламж, онгоцны буудал, боомт зэрэг ердийн хөрөнгийн адилаар чөлөөтэй захиран зарцуулах боломжгүй хөрөнгө хамаарна.

Харин бусад ердийн өмчийн хөрөнгөд тухайн үеийн нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан зохистойгоор, үр ашигтайгаар чөлөөтэй захиран зарцуулах боломж бүхий бүх төрлийн хөрөнгө хамаарна.

Ердийн өмчийг бүрдүүлж буй хөрөнгийг авч үзвэл, ердийн өмчийн хөрөнгө нь дор дурдсан хэлбэрээр үүсэж бий болсон байдаг. Үүнд:

- Захиргааны өмч байсан боловч актлагдах замаар ердийн өмчийн хөрөнгөд шилжсэн;
- Өв залгамжлалын татвар зэргийн үндсэн дээр төр өөрт хураан авах замаар бий болгосон хөрөнгө;
- Засгийн газраас хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт;
- АНУ-ын цэргийн баазад шилжүүлсэн хөрөнгө.

Мөн Татварын тухай хуулийн дагуу бэлэн мөнгөний оронд хураагдах байдлаар “ердийн хөрөнгө”-д хамаарах болсон аливаа хөрөнгө болон захиргааны үйл ажиллагааны хүрээнд ашиглагдахгүй болж, актлагдах

замаар “ердийн хөрөнгө”-д хамаарах болсон захиргааны хөрөнгө зэргээр ерөнхий байдлаар ялган авч үзэж болно. Ийнхүү төрийн өмчийг захиргааны болон ердийн өмч гэж ангилах шалтгааныг доор хүснэгтээр харуулав (Хүснэгт 1.).

Хүснэгт 1. Захиргааны өмч болон ердийн өмчийн ангилал, түүний шалтгаан

Зориулалт ⁵	Удирдах, захиран зарцуулах ⁶
Захиргааны өмч нь захиргааны үйл ажиллагаанд ашиглахад чиглэсэн хөрөнгө тул хувийн өмчийн харилцаанд оролцуулах шаардлага төдийлөн байхгүй.	Захиргааны өмч нь захиргаа үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хэрэгсэл тул тухайн хөрөнгийг харьяалах этгээдэд түүнийг удирдах эрхийг олгох нь үр дүнтэй.
Ердийн өмч нь төрийн өмчлөл бүхий эдийн засгийн хэрэгсэл тул хувийн эрх зүйн харилцаанд оролцуулах шаардлагатай.	Ердийн өмч нь эдийн засгийн хэрэгсэл тул тухайн хөрөнгийг захиран зарцуулах эрхийг нэг этгээдэд төвлөрүүлэх нь оновчтой.

Хүснэгт 1-ээс харахад, захиргааны болон ердийн өмчийн зориулалт нь ялгаатай байх тул түүнийг удирдах, захиран зарцуулах харилцааг ялгамжтай байдлаар зохицуулах шаардлага үүсдэг байна.

2.2. Төрийн өмчийн өнөөгийн байдал

Засгийн газар нь төрийн өмчийн хөрөнгийн нийт үнэлгээг жил бүр Парламентад тайлагнах үүрэгтэй байдаг. 2020 оны 7 сарын байдлаар Япон Улсын төрийн өмчийн нийт хөрөнгө 108.5 их наяд иенийн үнэлгээтэй байжээ⁷.

⁵ 国有財産法18条。

⁶ 国有財産法5条・6条。

⁷ 財務省理財局、「国有財産レポート7頁」令和2年7月7頁 [https://www.mof.go.jp/national_property/full-download-2.pdf].


Харин төрийн өмчийн ангиллаар авч үзвэл захиргааны өмчийн үнэлгээ 24.4 их наяд иен (22.4 хувь) байгаа бол ердийн өмчийн үнэлгээ 84.1 их наяд иен (77.6 хувь) байна⁸.

2.2.1 Захиргааны өмчийн өнөөгийн байдал

Захиргааны өмч нь төрийн нийт өмчийн ойролцоогоор 22.4 хувийг эзэлдэг бөгөөд албаны, нийтийн, хааны гэр бүлийн болон аж ахуйн зориулалтай өмчүүдээс бүрдэнэ.

Өмнө дурдсанчлан захиргааны өмчийн нийт үнэлгээ 24.2 их наяд иен бөгөөд үүнээс албаны өмчийн үнэлгээ 18.8, нийтийн өмчийн үнэлгээ 0.7, хааны гэр бүлийн өмчийн үнэлгээ тус тус 0.6 их наяд иен, аж ахуйн зориулалтай өмчийн үнэлгээ 4.1 их наяд иен байна⁹.

График 2. Захиргааны өмчийн бүтэц (хувиар)



Графикаас харахад, захиргааны өмчийн дийлэнх хэсгийг төрийн албаны үйл ажиллагаанд ашиглах зориулалт бүхий барилга, орон сууц зэрэг албаны өмчийн хөрөнгө эзэлжээ. Харин нийтийн өмч болон хааны гэр бүлийн өмчийн хөрөнгө нь 2-3 хувийг эзэлж байгаа бол аж ахуй зориулалтай өмчийн хөрөнгө нь 17 хувийг эзэлж байна.

⁸ 財務省理財局、「国有財産レポート7頁」令和2年7月7頁 [https://www.mof.go.jp/national_property/full-download-2.pdf].

⁹ 財務省理財局、「国有財産レポート7頁」令和2年7月7頁 [https://www.mof.go.jp/national_property/full-download-2.pdf].

Аж ахуйн зориулалттай өмчид зөвхөн ойн аж ахуй хамаарна. Уг ойн аж ахуй нь Япон Улсын нийт ойн талбайн 30 хувь орчим хувийг эзлэх бөгөөд Ой, ус хариуцсан яамны нэгж болох Ой хээрийн агентлагаас удирдан мод бэлтгэх, түүнийг хамгаалах үйл ажиллагаа явуулж байна.

2.2.2 Ердийн өмчийн өнөөгийн байдал

Засгийн газраас хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө¹⁰ оруулалтын нийт үнэлгээ 77.4 их наяд иен байна. Харин Япон дахь АНУ-ын цэргийн баазад ашиглуулж буй хөрөнгийн үнэлгээ 2.9 их наяд иен, нутгийн өөрөө удирдах байгууллагад цэцэрлэгт хүрээлэн байдлаар түрээслүүлж буй хөрөнгийн үнэлгээ 1.9, ашигладаггүй төрийн өмчийн газрын үнэлгээ 0.3, ой тайга, хээр талын үнэлгээ 1.5 их наяд иен байна¹¹.

График 3. Ердийн өмчийн бүтэц (хувиар)



Графикаас харахад, ердийн өмчийн дийлэнх хэсгийг Засгийн газраас хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт эзэлжээ. Харин бусад төрлийн өмчид хамаарах хөрөнгө нь ердийн өмчийн 0-4 хувийг эзэлж байна.

Ашигт малтмалын лиценз нь ердийн өмчийн бүтцэд хамаарах боловч маш бага хувийг эзэлдэг тул ердийн өмчийн бүтцийг илэрхийлсэн

¹⁰ Хуулийн этгээдийн төрлийг Хүснэгт 2-оос үзнэ үү.

¹¹ 財務省理財局、「国有財産レポート7頁」令和2年7月7頁 [https://www.mof.go.jp/national_property/full-download-2.pdf].

графикт төдийлөн оруулдаггүй. Өнөөгийн байдлаар ашигт малтмалын нийт үнэлгээний нь 300 сая иен байна¹². Энэхүү нөхцөл байдал Япон Улсын хэмжээнд ашигт малтмалын олборлолт явуулж буй төрийн өмчийн компани бараг байхгүйтэй холбоотой юм.

“Засгийн газрын хөрөнгө оруулалт” гэдэг нийтийн эрх ашгийн шинжтэй үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн тогтвортой байдлыг хангах үүднээс төрөөс бодлогын хүрээнд хөрөнгө оруулах замаар олж авсан хувьцаа, хөрөнгө оруулалтад суурилсан эрх зэргийг хэлнэ.

Төрийн өмчийн хөрөнгө дотор Засгийн газрын хөрөнгө оруулалтын үнэлгээ үлэмж байр суурийг эзэлдэг байна. 2020 оны 7 дугаар сарын байдлаар Засгийн газрын хөрөнгө оруулалтын үнэлгээ нь 77.4 их наяд иен (Төрийн нийт өмчийн үнэлгээ (108.5 их наяд иен)-ий ойролцоогоор 71.3 хувь) байх бөгөөд хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн тоо нь 228 хүрчээ.

Эдгээрээс бие даасан хууль бүхий компанийн хувьд төрийн зүгээс төрийн заавал эзэмших хувьцааны багцыг тогтоож өгөх замаар хөрөнгө оруулалт хийдэг ажээ. Төрийн заавал эзэмших хувьцааны багцад оруулсан хөрөнгө оруулалтын үнэлгээ нь 18.9 их наяд иен байх бөгөөд нийтийн төрийн эзэмшлийн хувьцааны үнэлгээний 80.7 хувийг эзэлж байна.

¹² Төрийн өмчийн тайлан [https://www.mof.go.jp/pri/publication/zaikin_geppo/hyou/g790/790_a.pdf]

Хүснэгт 2. Засгийн газрын хөрөнгө оруулалтын үнэлгээ болон хуулийн этгээдийн тоо (2020 оны эцсийн тайлан)¹³

Хуулийн этгээд	Бие даасан хууль бүхий компани	Бие даасан захиргааны хуулийн этгээд	ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага	Улсын их сургууль	Санхүүгийн байгууллага, ААН
Хуулийн этгээдийн тоо	29	83	11	90	15
Үнэлгээ	23.4 (18.9 үүрэг хүлээсэн) их наяд иен	32.1 их наяд иен	10.2 их наяд иен	7.0 их наяд иен	4.5 их наяд иен
Голлох хуулийн этгээдийн жагсаалт	1. NTT ¹⁴ 2. JP Post ¹⁵ 3. JT ¹⁶ 4. JFC ¹⁷ 5. DBJ ¹⁸	1. JICA 2. JEHDRA ¹⁹ 3. JHFA ²⁰ 4. OS&MERI ²¹	1. IMF ²² 2. IDA ²³	1. Tokyo Uni, 2. Osaka Uni, 3. Kyoto Uni, 4. KEK ²⁴	1. Bank of Japan 2. JRA ²⁵

¹³ Сангийн яамны вэб хуудас [https://www.mof.go.jp/national_property/list/stocks/kabushiki/shusshi2020.pdf]

¹⁴ Nippon Telegraph, Telephone Corporation

¹⁵ Japan Post

¹⁶ Japan Tobacco

¹⁷ Japan Financial Corporation

¹⁸ Development bank of Japan

¹⁹ Japan Expressway Holding and Debt Repay Agency

²⁰ Japan Housing Finance Agency

²¹ Organization for Small & Medium Enterprises and Regional Innovation, JAPAN

²² International Monetary Fund

²³ International Development Association

²⁴ High Energy Accelerator Research Organization

²⁵ Japan Racing Association

Төрийн заавал эзэмших хувьцааны багцыг хуульд дараах байдлаар тогтоож өгчээ.

Хүснэгт 3. Засгийн газрын хувьцааны эзэмшил²⁶

Компанийн нэр	Нийт үнэлгээ ²⁷	Эзэмших үүрэг хүлээсэн хувьцаа	Бусад	Заавал эзэмших хувьцааны багц
Japan Post	33,171	19,440	13,731	1/3
Nippon Telegraph & Telephone Corp.	31,932	29,635	2,288	1/3-ээс дээш
Japan Tobacco Inc.	18,300	18,300	-	1/3
Japan Finance Corp.	56,142	56,142	-	100
Development Bank of Japan Inc.	32,430	16,215	16,215	1/3, 1/2 ²⁸
Japan Bank for International Cooperation	26,790	26,790	-	100 хувь
Nippon Export Investment Insurance	7,948	7,948	-	100 хувь
Highway Road 6 companies	6,581	2,353	4,227	1/3-ээс дээш
New Kansai International Airport Co., Ltd	5,929	5,929	-	100 хувь
Japan Investment Corp.	4,774	3,338	1435	2/3-оос дээш
Tokyo Metro Co., Ltd	3,417	-	3417	-

²⁶ Сангийн яамны вэб хуудас [https://www.mof.go.jp/national_property/list/stocks/kabushiki/kabushiki2020.pdf]

²⁷ биллион иен

²⁸ Дээрх хувийг тодорхой төрлийн хөрөнгө оруулалтын дуусах хүртэл заавал эзэмшихээр тусгасан.

Narita International Airport	3,144	-	3144	-
Shoko Chukin Bank, Ltd	1,981	1,981	-	1/2
Japan Overseas Infrastructure Investment Corporation for Transport & Urban Development	496	274	222	1
Japan Environmental Storage & Safety Corp.	486	486	-	100 хувь
Other 9 companies	1,446	568	878	эшлэл ²⁹
Нийт үнэлгээ (их наяд иен)	23,4	18.9	4.5	

Төрийн заавал эзэмших хувьцааны багцад хамаарахгүй төрийн эзэмшлийн хувьцааг тухайн салбарын бодлогод үндэслэн аль болох хурдан бусдад худалдах замаар хөрөнгө оруулалтыг нөхөх зарчмыг баримтална. Мөн Засгийн газраас хөрөнгө оруулсан компанийн хувьцааны эрхийг салбарын яам хэрэгжүүлдэг. Ингэхдээ Сангийн яамны харьяа, Хөрөнгийн удирдлагын хэлтсээс гаргасан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх удирдамжийг баримтална³⁰. Уг удирдамжид зааснаар хувьцаат компанийн хувьд Компанийн тухай хуулийг баримтална.

Харин бие даасан хууль бүхий компани (Хүснэгт 2-ыг үзнэ үү)-ийн хувьд салбарын сайд нь төлөөлөн удирдах зөвлөлийг томилох, чөлөөлөх, өөрчлөн байгуулах, ногдол ашиг хуваарилах, компанийн дүрмийг өөрчлөх асуудалд зөвшөөрөл өгөх бөгөөд сайдын оролцоо компани бүрд ялгамжтай байдаг.

Бие даасан хууль бүхий компанийн хувьд салбарын сайд нь хувьцаа эзэмшигчийн хувиар дараах үйл ажиллагааг явуулна.

²⁹ Chuubu International Airport, Japan Alcohol Inc., Yokohama Kawasaki International Airport, Hanshin International Airport-оокс бусад 5 компанийн хувьд 1/2 болон түүнээс дээш хувийн эзэмшлийг шаарддаг байна.

³⁰ Сангийн яам, Хөрөнгө удирдлагын хэлтэс [https://www.mof.go.jp/national_property/list/stocks/kabushiki/giketuken/giketukenhoushin20171211.pdf].

1. Санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны стратегитай нь тогтмол танилцаж, бодлогын чиг үүргийг сайжруулахын хажуугаар үйл ажиллагааны болон хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх чиглэлээр тайлбар авах, харилцах;
2. Тухайн компани төдийгүй харилцагч нартай нь ч санал солилцох замаар үйл ажиллагааных нь нөхцөл байдлыг сайтар судлах;
3. Төрийг төлөөлөн удирдлагыг нь хэрэгжүүлж байгаа болохыг тодотгож, ил тод, хариуцлагатай байдлыг шаардах;
4. Сангийн яамны цахим хуудсаар дамжуулан шаардлагатай мэдээллийг нийтлэх;
5. Шаардлагатай тохиолдолд удирдамж, удирдамжийн дагуу хувьцаа эзэмшигчийн үйл ажиллагааг сайжруулах.

АНУ-д цэргийн бааз хэлбэрээр олгосон хөрөнгө

1960 онд АНУ, Япон Улсын хооронд байгуулагдсан “АНУ болон Япон Улсын аюулгүй байдал, хамтын ажиллагааны гэрээ (*Treaty of Mutual Cooperation and Security between the United States and Japan*)-ний дагуу АНУ нь Япон Улсын газар нутагт цэргийн бааз байршуулах эрхтэй болжээ. Улмаар уг гэрээний хүрээнд Япон Улсаас АНУ-ын цэргийн баазын хэрэглээнд тодорхой хэмжээний газрыг ашиглуулж эхэлсэн байдаг. Энэхүү газар нь ердийн өмчийн ангилалд хамаарах бөгөөд АНУ-ын цэргийн бааз нь зөвхөн ашиглах эрхийг хэрэгжүүлнэ. Одоогийн байдлаар АНУ-ын цэргийн баазад ашиглуулж буй Япон Улсын хөрөнгийн үнэлгээ 2.9 их наяд иен байна (*График 3-ыг харна уу*).

Нутгийн өөрөө удирдах байгууллагад олгосон хөрөнгө

Нутгийн өөрөө удирдах байгууллагад олгосон хөрөнгө (газар) нь төрийн ердийн өмчид хамаарна. Улмаар төрөөс тодорхой тохиолдолд хуульд заасан арга хэрэгслийн дагуу ердийн өмчийг нутгийн өөрөө удирдах байгууллагад хариу төлбөртэй болон төлбөргүйгээр эзэмшүүлж, ашиглуулж болно³¹. Одоогийн байдлаар нутгийн өөрөө удирдах байгууллагад цэцэрлэгт хүрээлэн байдлаар түрээслүүлж буй хөрөнгийн үнэлгээ 1.9 их наяд иен байна (*График 3-ыг харна уу*).

³¹ Сангийн яамны вэб хуудас, Төрийн өмчийн тайлан [https://www.mof.go.jp/pri/publication/zaikin_geppo/hyou/g790/790_a.pdf].

Ингэхдээ дараах гурван аргын үндсэн дээр шилжүүлэн түрээслүүлдэг. Үүнд:

1. Зах зээлийн үнээр түрээслүүлэх;
2. Бууруулсан үнээр түрээслүүлэх;
3. Хариу төлбөргүй түрээслүүлэх.

Ийнхүү нутгийн өөрөө удирдах байгууллагад олгох хөрөнгийн тухай ойлголт төрийн өмчийн хөрөнгийг орон нутагт ашиглуулах тухай ойлголт юм.

Үүнээс гадна нутгийн өөрөө удирдах байгууллага нь Япон Улсын Үндсэн хуулийн 94-р зүйлд заасны дагуу бие даасан өөрийн өмчлөлийн хөрөнгөтэй байх бөгөөд уг хөрөнгийг удирдах, захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлдэг. Нутгийн өөрөө удирдах байгууллагын хөрөнгийн харилцааг Нутгийн өөрөө удирдлагын тухай хуулиар зохицуулна³². Уг хуульд зааснаар нутгийн өөрөө удирдах байгууллагын хөрөнгийг “захиргааны хөрөнгө” болон “ердийн хөрөнгө” хэмээн ангилдаг³³.

Төрийн өмчийн газрыг удирдах, захиран зарцуулах

Ашиглаагүй төрийн өмчийн газрын хувьд төр зайлшгүй өмчлөх, эзэмших шаардлагатайгаас бусад газрыг хатуу хяналтын доор бусдад худалдах, ашиглуулах замаар төсөвт орлого төвлөрүүлэхэд эрмэлзэх зарчмыг баримталдаг. Тэргүүн ээлжид нутгийн өөрөө удирдах байгууллагад худалдах, тогтмол түрээслэх замаар ашиглуулах талаар судлах бөгөөд энэ төрлийн ашиглалт хийгдэх боломжгүй тохиолдолд хувийн хэвшилд олгож болохоор зохицуулжээ. Төрийн өмчийн газрыг удирдаж, захиран тухайн газар бүрийн байршил, хэмжээ, эргэн тойрны газрын ашиглалт, газар ашиглах төлөвлөгөө, зохицуулалт, онцлог зэргийг хангалттай түвшинд харгалзаж үзсэний үндсэн дээр түүнийг захиран зарцуулах хэлбэрийг сонгоно. Газрыг захиран зарцуулах хэлбэрүүдийг Хүснэгт 4-г харуулав.

³² 地方自治法（1947年）。

³³ 地方自治法238条3項・4項。

Хүснэгт 4. Газрыг захиран зарцуулах түгээмэл хэлбэрүүд

Худалдах	Нутгийн өөрөө удирдах байгууллагад гэрээгээр худалдахаас гадна дуудлага худалдаанд оруулах
Арилжаа хийх	Төр болон нутгийн өөрөө удирдах байгууллага ашиглах хэрэгцээндээ нийцүүлэн газрыг хоорондоо солих, төлөвлөж буй барилгыг барих боломжгүй газрыг хажуугийн газраар солих
Хөрөнгө итгэмжлэх	Төр газраа худалдах, түрээслэхээс илүүтэй хувийн салбарын хүчийг ашиглах нь үр ашигтай байх тохиолдолд хөрөнгө итгэмжлэх байгууллагад итгэмжлэн олгох замаар газрын үнэ цэнийг нэмэгдүүлэх

Ашиглаагүй төрийн өмчийн газрыг бусдад худалдах тохиолдолд дуудлага худалдаагаар худалдан борлуулах зарчмыг баримтална³⁴. Харин нутгийн өөрөө удирдах байгууллагад цэцэрлэгт хүрээлэнгийн зориулалтаар худалдах тохиолдолд гэрээний үндсэн дээр шилжүүлж болно³⁵. Мөн ашиглаагүй газрыг бусдад шилжүүлэх тохиолдолд “зохих ёсны хариу төлбөртэй байх зарчим”-ыг баримтална³⁶. Гагцхүү нийтийн зориулалтаар олон нийтийн хэрэгцээнд олгох тохиолдолд Төрийн өмчийн тухай хуулийн дагуу хариу төлбөргүйгээр эсхүл хямдруулсан үнээр худалдаж, түрээслүүлж болно³⁷. Төрийн өмчийн газрыг нийтийн зориулалтаар ашиглах хэлбэрийг Хүснэгт 5-д харуулав.

³⁴ 会計法 29 条の 3 第 1 項。

³⁵ 会計法 29 条の 3 第 5 項。

³⁶ 財政法 9 条 1 項。

³⁷ 国有財産法第 22 条ほか。

*Хүснэгт 5. Төрийн өмчийн ашиглаагүй газрыг
нийтийн зориулалтаар бусдад шилжүүлэх хэлбэрүүд*

Захиран зарцуулах хэлбэр	Зориулалт	Хууль
Шилжүүлэн олгох	Зам, гол горхины зориулалтаар	Төрийн өмчийн тухай хууль 28-р зүйл
Хариу төлбөргүй түрээслүүлэх	Цэцэрлэгт хүрээлэн, хог боловсруулах үйлдвэр, нийгмийн халамж, асрамжийн зориулалтай барилга	Төрийн өмчийн тухай хууль 22-р зүйл Төрийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 2-р зүйл
Хямдруулан түрээслүүлэх, худалдах	Сургууль, эмнэлэг, нийгмийн халамжийн зориулалттай барилга	Төрийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмын хууль 3-р зүйл
Зах зээлийн үнээр түрээслүүлэх, худалдах	-	-

Ийнхүү ашиглаагүй байгаа төрийн өмчийн газрыг удирдахдаа бусдад ашиглуулах замаар төсөвт орлого төвлөрүүлэх зарчмыг удирдлага болгож, Төрийн өмчийн тухай хуульд заасан ердийн өмчийн хөрөнгийг захиран зарцуулах хэлбэрүүд дотроос эдийн засгийн үр ашиг өндөртэй хэлбэрийг сонгодог байна. Ингэхдээ нутгийн өөрөө удирдах байгууллагад тэргүүн ээлжид ашиглуулах, нийтийн хэрэгцээнд олгох тохиолдолд хариу төлбөргүй эсхүл хямдруулсан үнээр түрээслүүлж болох зарчмыг тусгаж өгчээ.

2.3. Төрийн өмчийг удирдах этгээд

Япон Улс нь төрийн өмчийг удирдах хүрээнд төрийн өмчийн нэгдсэн удирдлага болон төрийн өмчийн тухайлсан удирдлагыг бий болгосон.

2.3.1. Төрийн өмчийн нэгдсэн удирдлага

Төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг Сангийн сайд хэрэгжүүлнэ³⁸. “Төрийн өмчийн нэгдсэн удирдлага” гэдэг нь төрийн өмчийг зохистой аргын дагуу захиран зарцуулахын тулд төрийн өмчийг удирдах нэгдсэн тогтолцоог бий болгож удирдах, захиран зарцуулах үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, түүний өсөлт, бууралт, одоогийн нөхцөл байдал, үнэлгээг тодорхой байлгах болон удирдах, захиран зарцуулахад шаардлагатай зохион байгуулалтыг хариуцахыг хэлнэ³⁹.

Улмаар Сангийн сайд нь төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч болно. Үүнд:

- төрийн өмчийн хөрөнгөд хамаарах баримт бичиг эсхүл мэдээллийг шаардаж, газар дээр нь судалгаа хийх, ашиглах зориулалтыг өөрчлөх, актлах, удирдах газрыг өөрчлөх, холбогдох арга хэмжээ авахыг шаардах;
- удирдах газрыг өөрчлөх талаар санал хүлээн авч, сонсох;⁴⁰
- төрийн өмчид хамаарах хөрөнгийг олж авах, захиран зарцуулах талаарх саналыг хүлээн авч, сонсох⁴¹.

Түүнчлэн, Сангийн сайд нь төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг хэсэгчилсэн байдлаар доод шатны захиргааны байгууллагад эрх шилжүүлж болно⁴².

³⁸ 国有財産法7条。

³⁹ 国有財産法4条。

⁴⁰ 国有財産法12条。

⁴¹ 国有財産法14条。

⁴² 国有財産法9条1項・2項。

2.3.2. Төрийн өмчийн тухайлсан удирдлага

Төрийн өмчийн тухай хуулиар төрийн өмчийг захиргааны болон ердийн өмч хэмээн ангилах замаар түүний тухайлсан удирдлагын механизмыг ялгамжтай байдлаар зохицуулжээ. Захиргааны өмчийн хувьд тухайлсан удирдлагыг тухайн хөрөнгийг харьяалах яам, агентлаг хэрэгжүүлнэ⁴³.

Харин яам, агентлагийн тухайлсан удирдлагын үйл ажиллагаанд Сангийн сайд нэгдсэн удирдлага хэрэгжүүлэгчийн хувиар хяналт тавина. Харин цэцэрлэгт хүрээлэн, нийтийн талбай зэрэг нийтийн өмчийг актлах замаар ангилал, зориулалтыг нь өөрчлөх тохиолдолд зарчмын хувьд Парламентаар хэлэлцүүлнэ⁴⁴.

Нөгөө талаас, Сангийн сайд ердийн өмчийн тухайлсан удирдлагыг хэрэгжүүлж, захиран зарцуулна⁴⁵. Энэ хүрээнд цаашид ашиглахгүй захиргааны өмчийг яам, агентлагийн дарга нар актлах замаар ердийн өмч болгож, Сангийн сайдад шилжүүлэн өгөх шаардлагатай байдаг 8-р зүйл). Харин өөр хөрөнгөөр солих, устгалд оруулах зорилгоор акталж байгаа хөрөнгийг Сангийн сайдад шилжүүлэх шаардлагагүй бөгөөд яам, агентлагийн дарга нар өөрийн үзэмжээр захиран зарцуулах эрхтэй.

Яам, агентлагийн дарга нар нь дараах тохиолдолд Сангийн сайдтай зөвшилцөх ёстой⁴⁶. Үүнд:

- Захиргааны өмчийн зориулалтаар газар, барилга олж авах;
- Ердийн өмчийг захиргааны өмч болгох ;
- Захиргааны өмчийн төрлийг өөрчлөх;
- Захиргааны өмчийн газар, барилгын харьяалал, зориулалтыг өөрчлөх;
- Захиргааны өмчийн барилгыг шинэчлэх;
- Захиргааны өмчийг бусад яам, агентлагт шилжүүлэх;
- Төрөөс өөр этгээдэд захиргааны өмчийг шилжүүлж, ашиг олох боломж олгох;
- Ердийн өмчийн газрыг итгэмжлэх замаар бусдад шилжүүлэх.

⁴³ 国有財産法5条。

⁴⁴ 国有財産法13条。

⁴⁵ 国有財産法6条。

⁴⁶ Парламентад хэлэлцүүлэх шаардлагатай эсхүл Засгийн газрын тогтоолд өөрөөр заасан бол үүнд хамаарахгүй.

Ийнхүү төрийн өмчийн тухайлсан удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн этгээдийн хүрээнд яам, агентлагийн дарга нарыг хуульчилж өгсөн боловч тодорхой тохиолдолд Сангийн сайд болон Парламентын оролцоог тусгаж өгснөөрөө онцлогтой байна.

2.4. Төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах

Төрийн өмчийг олж авах, арчлан хамгаалах, хадгалах, ашиглалтад олгох харилцааг “Төрийн өмчийг удирдах” гэнэ. Харин “төрийн өмчийг захиран зарцуулах” гэж худалдах, арилжаа хийх, шилжүүлэн олгох, хөрөнгө итгэмжлэх, түрээслүүлэх зэрэг үйл ажиллагааг хэлнэ. Төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах хэлбэр нь тухайн өмчийн хөрөнгө нь захиргааны өмч болон ердийн өмчийн хөрөнгө байхаас хамааран ялгаатай байна.

2.4.1. Захиргааны өмчийг удирдах, захиран зарцуулах

Захиргааны өмчийг яам, агентлагийн дарга нар удирдана⁴⁷. Яам, агентлагийн дарга нарын зүгээс захиргааны өмчийг удирдахдаа Төрийн өмчийн тухай хуульд зааснаас бусад тохиолдолд захиран зарцуулахыг хориглодог⁴⁸. Энэхүү захиргааны өмчийг захиран зарцуулахыг хориглосон тохиолдолд дараах хэлбэрүүд хамаарна. Үүнд:

- түрээслүүлэх;
- арилжаа хийх (өөр хөрөнгөөр солих);
- худалдах;
- хөрөнгө итгэмжлэх;
- хөрөнгө оруулах;
- хувийн эрх зүйн эрх олгох (газарт хамаарах Япон Улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн онцлог эрхүүд (地上権・地役権, сервитут).

⁴⁷ 国有財産法5条。

⁴⁸ 国有財産法18条。

Харин төрийн өмчийн тухай хуульд заасны дагуу гагцхүү дараах тохиолдолд тухайн хөрөнгийн зориулалтад нийцсэн хүрээнд түрээслүүлэх эсхүл хувийн эрх зүйн эрх олгож болно⁴⁹. Үүнд:

- Төрөөс өөр этгээд захиргааны өмчийн газар дээр барилга барих эсхүл үр тариа тарих гэж байгаа бөгөөд тухайн газрын хэрэглээний зорилгод нийцсэн байдлаар ашиглах гэж буй тохиолдолд тухайн этгээдэд⁵⁰ газрыг түрээслүүлэх;
- Төрөөс нутгийн өөрөө удирдах байгууллага эсхүл Засгийн газрын тогтоолд заасан хуулийн этгээдтэй захиргааны өмчийн газрын дээрх барилгыг хамтран өмчлөхийн тулд тухайн этгээдэд газрыг түрээслүүлэх;
- Төрөөс захиргааны өмчийн газар болон түүний хажуугийн газар дээр байгаа барилгыг төрөөс өөр этгээдтэй хамтран өмчлөхийн тулд тухайн этгээдэд газрыг түрээслүүлэх;
- Төрийн байгууллагын зориулалтай барилгын хэрэглээний тухай тусгай хуулийн 2.2-т заасан барилгын дотоод болон гадаад талбайд илүүдэл байгаа хэмээн Засгийн газраас тогтоосон тохиолдолд тухайн илүүдэл хэсгийг бусдад түрээслүүлэх;
- Захиргааны өмчийн газрын ашиглах эрхийг нутгийн өөрөө удирдах байгууллага эсхүл Засгийн газрын тогтоолд заасан хуулийн этгээдийн ажиллуулж байгаа төмөр зам, машин зам болон бусад Засгийн газрын тогтоолд заасан байгууламжийн зориулалтаар тухайн этгээдэд олгох;
- Захиргааны өмчийн газарт нутгийн өөрөө удирдах байгууллага, эсхүл Засгийн газрын тогтоолд заасан хуулийн этгээдийн ашиглаж буй гэрлийн шугам болон Засгийн газрын бусад тогтоолд заасан байгууламжийн зориулалтаар тухайн этгээдэд сервитут эрх олгох.

Түүнчлэн дээр дурдсан хэлбэрээр захиргааны өмчийн газрыг түрээсэлж авсан этгээд нь тухайн газар дээрх барилгын өөрт ногдох хэсгийг бусдад шилжүүлэх тохиолдолд тухайн хөрөнгийг харьяалах яам, агентлагийн дарга нарын тохиромжтой гэж үзсэн этгээдэд шилжүүлэн түрээслүүлж

⁴⁹ 国有財産法18条2項。

⁵⁰ Тухайн этгээд гэж тухайн хөрөнгийг харьяалах яам, агентлагуудын дарга нар зохих журмын дагуу тохиромжтой гэж үзсэн этгээдийг хэлнэ.

болно⁵¹. Мөн захиргааны өмчийн зориулалтад нийцсэн тохиолдолд тухай хөрөнгийг бусдад ашиглуулж, түүнээс ашиг хүртэх боломжийг зөвшөөрч болно. Тухайлбал, нутгийн өөрөө удирдах байгууллага нь хуульд заасан хуулийн этгээд эсхүл нийтийн өмчлөлийн компани захиргааны өмчийг зам, усан сувгийн зориулалтаар тухайн газрыг ашиглах эрх, сервитутын эрхийг олж авсан тохиолдолд тухайн этгээд газрыг хариу төлбөргүй түрээслүүлэх эсхүл ашиг олох боломжийг олж авч болохоор зохицуулсан байна⁵².

Харин хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрээр захиргааны өмчийг захиран зарцуулсан тохиолдолд эрх зүйн дагаврын хувьд тухайн хэлцэл нь хүчин төгөлдөр бус байхаар зохицуулжээ⁵³.

2.4.2. Ердийн өмчийг удирдах, захиран зарцуулах

Ердийн өмчийг Сангийн сайд удирдана⁵⁴. Ингэхдээ ердийн өмчийн хамаарах хөрөнгийг дараах хэлбэрээр захиран зарцуулж болно⁵⁵. Үүнд:

- түрээслүүлэх;
- удирдлагыг шилжүүлэх;
- арилжаа хийх (өөр хөрөнгөөр солих);
- худалдах;
- шилжүүлэн олгох;
- хөрөнгө итгэмжлэх;
- бусад аргаар хувийн эрх зүйн эрх олгож болно.

Мөн ердийн өмчийн хөрөнгийг хуульд зааснаас бусад тохиолдолд хөрөнгө оруулах зорилгоор ашиглаж болохоор зохицуулсан байна⁵⁶.

Түүнчлэн ердийн өмчийг захиран зарцуулах хүрээнд Төрийн өмчийн тухай хуульд нийцүүлэн 1952 онд батлагдсан Төрийн өмчийн тусгай арга хэмжээний тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Уг хуулийн зорилго нь нийтийн эрх ашгийг дээдлэх, иргэдийн тогтвортой байдал,

⁵¹ 国有財産法18条3項。

⁵² 国有財産法18条7項。

⁵³ 国有財産法18条5項。

⁵⁴ 国有財産法6条。

⁵⁵ 国有財産法20条。

⁵⁶ 国有財産法20条2項。

аж ахуйн үйл ажиллагаанд Төрийн өмчийн тухай хууль дахь “төрийн ердийн өмч”-ийн хөрөнгийг үр дүнтэй ашиглуулахын тулд түүнийг удирдах, захиран зарцуулах тусгай журмыг бий болгоход чиглэсэн⁵⁷. 1952 оны Төрийн өмчийн тусгай арга хэмжээний тухай хууль нь дараах бүтэцтэй. Үүнд:

1-р зүйл. Зорилго

2-р зүйл. Хариу төлбөргүй түрээслүүлэх

3-р зүйл. Хямдруулан түрээслүүлэх

4-р зүйл. ... хүчингүйд төөцсөн

5-р зүйл. Шилжүүлэх олгох

6-р зүйл. Төсөөтэй хэрэглэх

7-р зүйл. Нөхцөл заах замаар худалдах, түрээслүүлэх

8-р зүйл. ...⁵⁸

9-р зүйл. Арилжаа хийх

10-р зүйл. Зарим төрлийн ердийн өмчийн хөрөнгийг захиран зарцуулах

11-р зүйл. Хариу төлбөрийн тусгай журам.

Энэ судалгааны хүрээнд Төрийн өмчийн тусгай арга хэмжээний тухай хуульд төдийлөн анхаарал хандуулахгүй бөгөөд түүний ерөнхий хууль болох Төрийн өмчийн тухай хуулийн ерөнхий зохицуулалтыг голчлон авч үзнэ.

2.4.3. Ердийн өмчийг захиран зарцуулах хэлбэрүүд

Төрийн өмчийн тухай хуульд ердийн өмчийг захиран зарцуулах хэлбэрийг дараах байдлаар тогтоож өгсөн. Эдгээрийг нарийвчлан авч үзье.

Түрээслүүлэх

Ердийн өмчийг түрээслүүлэх харилцааг түрээслүүлэх үндсэн нөхцөл, хариу төлбөргүйгээр түрээслүүлэх, түрээсийн гэрээ цуцлах гэсэн хэсэгт хуваан авч үзнэ.

⁵⁷ 国有財産特別措置01条。

⁵⁸ 8-р зүйлд нэр байхгүй бөгөөд агуулгын хувьд 7-р зүйлтэй холбогдоно.

Түрээслүүлэх үндсэн нөхцөл

Ердийн өмчид хамаарах хөрөнгийг хариу төлбөртэйгөөр бусдад ашиглуулах харилцааг “Түрээслүүлэх” гэнэ. Төрийн өмчийн тухай хуульд ердийн өмчид хамаарах хөрөнгийг дараах хугацаатайгаар бусдад түрээслүүлэхээр зохицуулжээ⁵⁹.

- Мод тарих зориулалтаар газар болон түүнтэй нэгдмэл зүйл (барилга хамаарахгүй)-ийг түрээслэх тохиолдолд 60 хүртэлх жилээр;
- Барилга өмчлөх зориулалтаар газар болон түүнтэй нэгдмэл зүйлийг түрээслүүлэх тохиолдолд 50 хүртэлх жилээр;
- Дээрх хоёр тохиолдолд үл хамаарах зориулалтаар газар болон түүнтэй нэгдмэл зүйлийг түрээслүүлэх тохиолдолд 30 хүртэлх жилээр;
- Барилга болон бусад хөрөнгийг түрээслүүлэх тохиолдолд 10 хүртэлх жилээр.

Мөн барилга өмчлөхөөс бусад зориулалтаар газар түрээслүүлэх гэрээг сунгаж болох бөгөөд ийнхүү сунгасан өдрөөс уг хуульд заасан хугацаа шинээр үйлчилнэ. Харин түрээсийн төлбөрийн хувьд жил бүр тогтсон хугацаанд төлөх ёстой боловч түрээслэгчийн боломжийг харгалзан урьдчилан төлж болно⁶⁰.

Хариу төлбөргүй түрээслүүлэх⁶¹

Ердийн өмчийн хөрөнгийг зарчмын хувьд хариу төлбөртэйгөөр түрээслүүлэх боловч дараах тохиолдолд олон нийтийн байгууллагад⁶² хариу төлбөргүйгээр түрээслүүлж болохоор зохицуулсан⁶³. Үүнд:

- Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, цөөрөм, ус зайлуулах хоолой, чандарлах газар, оршуулгын газар, хог боловсруулах байгууламж, ялгадас боловсруулах байгууламж, мал нядалгааны

⁵⁹ 国有財産法21条。

⁶⁰ 国有財産法23条。

⁶¹ Монгол хэл дээрх хууль зүйн нэр томъёоны хувьд “үнэ төлбөргүй ашиглуулах” гэсэн томъёоллоор ойлгоно.

⁶² Нутгийн өөрөө удирдах байгууллага, Усны аюулаас сэргийлэх нөхөрлөл, Газрыг сэргээх байгууллага зэрэг хамаарна.

⁶³ 国有財産法22条。

- байгууламж, замын гэрэлтүүлэг, дохио, тэмдэглэгээ болон бусад нийтийн зориулалттай хэмээн тогтоосон байгууламжид олгох;
- Хамгаалах шаардлагатай байгаа орон гэргүй хүмүүст зориулж олгох;
 - Гамшиг бий болсон тохиолдолд яаралтай арга хэмжээний зориулалтаар олгох;
 - Хүчтэй газар хөдлөлттэй тэмцэх тухай хуульд⁶⁴ заасан яаралтай арга хэмжээ авах хүрээнд олгох;
 - Цөмийн аюултай тэмцэх тухай хуульд заасан яаралтай арга хэмжээг авах хүрээнд олгох⁶⁵;
 - Терроризмтой тэмцэх тухай хуульд заасны дагуу иргэдийг хамгаалах яаралтай арга хэмжээг авах хүрээнд олгох⁶⁶.

Харин олон нийтийн байгууллагын ажиллуулж буй байгууламж нь ашгийн төлөө зорилготой эсхүл үйл ажиллагааны зорилгоо ашгийн төлөө болгож өөрчилсөн тохиолдолд хариу төлбөргүйгээр түрээслүүлэхийг хориглоно⁶⁷. Хэрэв яам, агентлагийн дарга нарын бусдад хариу төлбөргүйгээр түрээслүүлсэн ердийн өмчид хамаарах хөрөнгө нь хөрөнгийн удирдлагын хувьд зохих ёсны бус байх эсхүл хуульд харшлах тохиолдолд гэрээг нэн даруй цуцлах үүргийг хүлээдэг.

Түрээсийн гэрээг цуцлах

Яам, агентлагийн дарга нар нь төр эсхүл олон нийтийн байгууллагын олон нийтийн хэрэгцээ, эрх ашгийн үүднээс байгуулсан түрээсийн гэрээг цуцалж болно⁶⁸. Гэрээг цуцалсантай холбоотойгоор түрээслэгчид учирсан хохирлыг тухайн хөрөнгийг харьяалах яам, агентлаг хариуцан нөхөн төлнө. Энэ тохиолдолд яам, агентлагийн дарга нар нь түрээслэгчид учирсан хохирлын талаар дүгнэлт гаргуулахаар Төрийн аудитын хяналтыг оруулж болох бөгөөд түүнээс гаргасан дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ⁶⁹.

⁶⁴ 大規模地震対策特別措置法（昭和五十三年法律第七十三号）。

⁶⁵ 原子力災害対策特別措置法（平成十一年法律第一百五十六号）。

⁶⁶ 武力攻撃事態等における国民の保護のための措置に関する法律（平成十六年法律第百十二号）。

⁶⁷ 国有財産法22条2項。

⁶⁸ 国有財産法24条。

⁶⁹ 国有財産法25条。

Удирдлагыг бусдад даалгах

Яам, агентлагийн дарга нар нь ердийн өмчийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх үүднээс шаардлагатай тохиолдолд тохиромжтой этгээдэд түүний удирдлагыг даалгаж болно⁷⁰. Хөрөнгийн удирдлагыг хүлээж авсан этгээд нь тухайн хөрөнгийг түүний зориулалтад нийцүүлэн яам, агентлагийн даргын зөвшөөрлийн үндсэн дээр ашиглаж, түүнээс ашиг хүртэхийн хажуугаар удирдлагыг хэрэгжүүлэхэд гарсан зардлыг хариуцна. Хэрэв хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд гарсан зардал нь түүнээс олж буй ашгаас давсан тохиолдолд яам, агентлагийн даргын тогтоосон хэмжээнд зөрүүг нөхөн төлж болно⁷¹.

Арилжаа хийх (өөр хөрөнгөөр солих)

Ердийн өмчид хамаарах хөрөнгө нь газар болон түүнтэй нэгдмэл зүйл, салгах боломжгүй барилга байх тохиолдолд төр болон олон нийтийн зориулалтаар, эсхүл нийтийн эрх ашгийн үүднээс адил төрлийн хөрөнгөөр сольж болно. Сольж буй хөрөнгийн үнийн зөрүүг бэлэн мөнгөөр төлөх боловч үнийн зөрүү нь ¼-ээс хэтэрсэн тохиолдолд солихыг хориглоно⁷². Хэсэгчлэн салгах боломжгүй барилгыг өөр барилгаар сольж байгаа тохиолдолд яам, агентлагууд нь Төрийн аудитад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

Шилжүүлэн олгох

Шилжүүлэн олгох гэж “хуульд заасан тохиолдолд ердийн өмчид хамаарах хөрөнгийн өмчлөх эрхийг хуульд заасан этгээдэд хариу төлбөргүйгээр шилжүүлэх харилцааг” хэлнэ.

Ердийн өмчид хамаарах хөрөнгийг дараах тохиолдолд шилжүүлж болно⁷³.

1. Олон нийтийн байгууллагаас хадгалах болон засвар үйлчилгээний зардлыг нь хариуцаж байсан олон нийтийн өмчийг акталсан тохиолдолд тухайн олон нийтийн байгууллагаас гаргасан зардалд нь дүйцүүлж хөрөнгийг шилжүүлэн олгох.

⁷⁰ 国有財産法26条2項。

⁷¹ 国有財産法26条4項。

⁷² 国有財産法27条。

⁷³ 国有財産法28条。

2. Хандивын замаар бий болсон хөрөнгийг акталсан тохиолдолд тухайн хөрөнгийг хандивлагч эсхүл түүний өв залгамжлагчид шилжүүлэх. Харин хандивлах үед тусгайлан тохиролцсон эсхүл хандиваас хойш 20 жил өнгөрсөн хөрөнгийг буцаан шилжүүлэн олгохыг хориглоно.
3. Олон нийтийн байгууллагад чандарлах байгууламж, оршуулгын газар, хог боловсруулах байгууламж, ялгадас боловсруулах газар эсхүл мал нядалгааны газрын зориулалтаар ердийн өмчийг шилжүүлэн олгох. Харин тухайн байгууламж, газар нь ашгийн төлөө зориулалттай тохиолдолд шилжүүлэн олгохыг хориглоно.

Ийнхүү шилжүүлэн олгох хэлбэр нь хуульд заасан тохиолдолд тодорхой этгээдийн хүрээнд явагдах хязгаарлагдмал түвшний харилцаа юм.

Хөрөнгө итгэмжлэх

Хөрөнгө итгэмжлэх гэж “бусдын өмчлөлийн хөрөнгийг итгэмжлэлийн үндсэн дээр тухайн этгээдийн хүсэл зоригийн хүрээнд удирдах, ашиг хуваарилах харилцааг” хэлнэ.

Ердийн өмчид хамаарах газрыг хуульд заасны дагуу хөрөнгө итгэмжлэх замаар бусдад шилжүүлж болно⁷⁴. Харин дараах тохиолдолд хөрөнгө итгэмжлэх замаар бусдад шилжүүлэхийг хориглоно. Үүнд:

- Хариу төлбөргүйгээр түрээслүүлэх, арилжаа хийх эсхүл шилжүүлэн олгох зорилготойгоор итгэмжилж буй тохиолдолд;
- Хөрөнгө итгэмжлэлийн үр дүнд төрөөс өөр этгээд ашиг хүртэх тохиолдолд;
- Газрыг итгэмжлэх замаар олох ашиг нь түрээслүүлэх эсхүл худалдах замаар олох ашгаас бага тохиолдолд.

Яам, агентлагийн дарга нар нь хөрөнгө итгэмжлэх замаар газар шилжүүлэх тохиолдолд хуулийн дагуу дараах зүйлсийг холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

- Итгэмжлэх зорилго;
- Итгэмжлэгчийг сонгох арга;
- Итгэмжлэлийн үндсэн дээр олох орлого;

⁷⁴ 国有財産法28条2項。

- Итгэмжлэгч нь хөрөнгийг итгэмжлэхэд тодорхой хэмжээний мөнгө зээлэх шаардлагатай бол түүний хэмжээ;
- Засгийн газраас тогтоосон бусад зүйлс.

Яам, агентлагийн дарга нар нь газрыг итгэмжлэх замаар зарцуулах тохиолдолд Төрийн аудитад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Мөн хөрөнгийг итгэмжлэн удирдагч этгээдээс тухайн хөрөнгийн талаар мэдээлэл, тайлан шаардаж, газар дээр нь хяналт хийж, шаардлагатай зааварчилгааг өгч болно.

Хөрөнгө итгэмжлэх хугацааны хувьд 20 жилээс хэтэрч болохгүй бөгөөд сунгах тохиолдолд тухайн өдрөөс хойш 20 жилээс хэтрэхгүй байна⁷⁵.

Худалдах

Яам, агентлагийн дарга нар нь ердийн өмчид хамаарах хөрөнгийг бусдад худалдах тохиолдолд худалдан авах этгээдэд түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглах хугацааг тогтоож өгнө⁷⁶. Харин хууль тогтоомжид өөрөөр заасан тохиолдолд зориулалт болон ашиглах хугацааг тогтоож өгөхгүй байж болно.

Хөрөнгийн зориулалт, ашиглах хугацааг тогтоож өгсөн бол худалдан авагч нь зориулалтын дагуу эсхүл тогтоосон хугацаанд ашиглаагүй тохиолдолд яам, агентлагийн дарга нар нь нэг талын санаачилгаар гэрээг цуцалж болдог⁷⁷.

Мөн худалдаж байгаа тохиолдолд тухайн хөрөнгийг шилжүүлэхээс өмнө төлбөрийг бүрэн хийсэн байх шаардлага тавьдаг. Харин худалдан авагч нь олон нийтийн байгууллага эсхүл боловсрол, нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг бол түүний төлбөрийн чадварыг сайтар нягталж үзсэний үндсэн дээр барьцаа авч, хүү тооцох замаар 5 жилийн дотор төлөх байдлаар тусгайлан тохирч болно. Хэрэв яам, агентлагийн дарга нар нь гэрээ байгуулах үед төлбөрийг хойшлуулах тохиролцоо хийхээр бол ийнхүү хойшлуулах хугацаа, барьцаа, хүүгийн талаар Сангийн сайдтай зөвшилцөх ёстой.

⁷⁵ 国有財産法28条3項。

⁷⁶ 国有財産法29項。

⁷⁷ 国有財産法30条。

Түүнчлэн ердийн өмчид хамаарах хөрөнгийг захиран зарцуулах бүхий л хэлбэрийн хүрээнд Төрийн өмчийн хуульд зааснаас бусад тохиолдолд зохих ёсны хариу төлбөргүйгээр бусдад шилжүүлэн олгох эсхүл түрээслэхийг хориглодог⁷⁸. Гагцхүү нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглах тохиолдолд л хариу төлбөргүй эсхүл төлбөрийг бууруулж бусдад худалдах, түрээслүүлэхийг зөвшөөрдөг⁷⁹.

2.5. Төрийн өмчийн харьяаллыг өөрчлөх

Төрийн өмчийн харьяаллыг өөрчлөх гэж “Парламентын дээд болон доод танхим, Ерөнхий сайд, сайд нар, Улсын дээд шүүх, Төрийн аудитын дарга нарын хооронд төрийн өмчийг шилжүүлэх харилцаа”-г хэлнэ.⁸⁰

Төрийн өмчийн хөрөнгийн харьяаллыг өөрчлөх замаар өөртөө шилжүүлж авах сонирхолтой яам, агентлагийн дарга нь тухайн хөрөнгийг харьяалах яам, агентлагийн дарга болон Сангийн сайдтай зөвшилцөнө. Улмаар Сангийн сайд нь эцсийн шийдвэрийг гаргана. Мөн байгууллагын хоёр болон түүнээс дээш хэлтэс хооронд төрийн өмчийг шилжүүлэн хэрэглэж болно.

2.6. Төрийн өмчид нэвтрэх, хил хязгаарыг тогтоох

2.6.1. Төрийн өмчид нэвтрэх

“Төрийн өмчид нэвтрэх” тухай ойлголт нь төрийн өмчийн газрын тухайд л яригдана. Уг хуульд зааснаар яам, агентлагийн дарга нар нь шаардлагатай үед өөрт хамаарах төрийн өмчийн хөрөнгийг судлах, үнэлэх зорилгоор өөрийн ажилтныг бусдын эзэмшил газарт нэвтрүүлж болно⁸¹. Ингэхдээ тухайн газрын эзэмшигчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Эзэмшигчийн оршин байгаа газрыг мэдэхгүй тохиолдолд нийтэд зарлах замаар мэдээлж болно. Харин хашаа, тороор

⁷⁸ 財政法9条2項。

⁷⁹ 国有財産法22条。

⁸⁰ 国有財産法4条2項。

⁸¹ 国有財産法31条2項。

хүрээлэгдсэн газарт нэвтрэх тохиолдолд газрын эзэмшигчид заавал мэдэгдэх үүрэгтэй.

Мөн бусдын газарт нэвтрэхдээ биеийн байцаалтаа үзүүлэх бөгөөд хамт явж байгаа этгээдүүд ч өөрийн мэдээллийг өгөх ёстой. Тухайн газарт нэвтрэхдээ бусдын хөрөнгөд хохирол учруулсан бол ердийн байдлаар учирч болох хохирлыг яам, агентлагийн дарга нар нөхөн төлөхөөр зохицуулсан⁸².

2.6.2. Хил хязгаарыг тогтоох

Төрийн өмчийн газрын хил хязгаар тодорхой бус байгаагаас шалтгаалан тухайн газрын удирдлагыг хэрэгжүүлэхэд саад үүсэж байгаа бол яам, агентлагийн дарга нар нь хөрш газрын өмчлөгчтэй уулзалт зохион байгуулж болно. Тухайн этгээдэд уулзах газар, цагийг мэдэгдэнэ⁸³. Хөрш газрын өмчлөгч нь яам, агентлагийн даргын зүгээс зохион байгуулсан уулзалтад оролцох үүрэгтэй бөгөөд оролцоогүй тохиолдолд тухайн газар байршиж буй хот, дүүрэг, хорооны ажилтныг судалгаа хийлгэх замаар оролцуулан, хил хязгаарыг тогтоож болно.

Газрын өмчлөгч болон бусад эрх бүхий этгээд нь яам, агентлагийн дарга нарын тогтоосон хил хязгаартай санал нийлэхгүй тохиолдолд 60 хоногийн дотор шалтгааныг бичиж хүргүүлэх ёстой. Ийнхүү санал нийлэхгүй байгаа тухай мэдэгдэл 60 хоногийн дотор ирээгүй тохиолдолд шийдвэр албан ёсны болдог байна.

2.7. Ил тод байдал, тайлагнал

2.7.1. Төрийн өмчийн журнал

Төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах процессыг зохистой, үр дүнтэй явуулахын тулд төрийн өмчийн өнөөгийн байдлыг хянах

⁸² 国有財産法31条2項5号。

⁸³ 国有財産法 31条3項。

шаардлагатай байдаг. Улмаар яам, агентлагууд⁸⁴ эсхүл тэдгээрийн доод шатны байгууллагууд нь төрийн өмчийн журнал хөтөлж, өөрт харьяалагдах хөрөнгийг бүртгэх үүрэг хүлээнэ⁸⁵.

Төрийн өмчийн журналд хөрөнгийн ангилал (газар, мод, барилга, тариа будаа гэх ангилал), төрөл (байгууламж барих газар, орон сууцны газар, хээр тал зэргийн ангилал, барилгын хувьд оффисын барилга, орон сууцны барилга гэх ангилал), байршил, тоо хэмжээ, үнэ, олж авсан, устгалд оруулсан, шилжүүлсэн он сар өдөр, түүний шалтгаан, бусад шаардлагатай зүйлс зэргийг бүртгэнэ.

Төрийн өмчид шинээр олж авсан, харьяалах газрыг нь өөрчилсөн, захиран зарцуулсан, бусад үндэслэлээр өөрчлөлт орсон бол түүний өсөлт, бууралтыг журналд бүртгэнэ. Төрийн өмчийн бүхий л хөрөнгийг журналд бүртгэх боловч зарим төрлийн хөрөнгийг бас бүртгэхгүй байхаар зохицуулсан. Үүнд:

- нийтийн зориулалтай цэцэрлэгт хүрээлэн, олон нийтийн зориулалтай хэмээн тогтоосон бусад зүйлс (газар, гол горхи, далай нуурын эрэг г.м.);
- ердийн хөрөнгө дотроос нутгийн өөрөө удирдах байгууллагад түрээслүүлсэн хөрөнгө хамаарна.

Эдгээр хөрөнгө нь гагцхүү олон нийтийн зориулалтаар ашиглагдах бөгөөд түүнийг төрийн зүгээс захиран зарцуулах боломж хязгаарлагдмал байх тул төрийн өмчийн журналд бүртгэх нь ач холбогдол багатай юм.

Төрийн өмчийн журналд хөрөнгө тус бүрийн үнэлгээг тусгах бөгөөд хөрөнгийн үнэлгээ нь зарчмын хувьд тухайн хөрөнгийг олж авсан үеийн үнэлгээнд суурилсан байх ёстой. Уг үнэлгээнд жилд нэг удаа өөрчлөлт оруулах шаардлагатай байдаг⁸⁶.

⁸⁴ Төрийн өмчийн тухай хуулийн 32-р зүйлд заасны дагуу “яам, агентлагууд” гэдэгт Парламентын дээд болон доод танхим, Засгийн газар, түүний яам, агентлагууд, Улсын Дээд шүүх хамаарна.

⁸⁵ 国有財産法32条。

⁸⁶ Төрийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмын тухай хууль 23-р зүйл (төрийн өмчийн аж ахуйн нэгжийн үнэлгээнд хамаарахгүй)

Нэмэлт мэдээлэл:

- 1) Өмнө нь нээлттэй хувьцаат компанийн үнэт цаас, Засгийн газрын хөрөнгө оруулалтаас бусад хөрөнгийн хувьд 5 жилд нэг удаа шинэчилсэн үнэлгээ хийхээр зохицуулсан байсан боловч төрийн өмчийн хөрөнгийн үнэлгээг бодитой байлгах үүднээс жилд нэг удаа үнэлгээний хийхээр нэмэлт өөрчлөлт оруулсан;
- 2) Үнийн өөрчлөлт хийхдээ баримтлах арга
 - Газрын хувьд өв залгамжлалын татварын үнэлгээний арга;
 - Барилга, үр тариа зэргийн хувьд журналд бүртгэгдсэн үнэлгээ болон одоогийн үнэлгээний өөрчлөлтийг харьцуулах;
 - Нээлттэй хувьцаат компанийн үнэт цаасны хувьд зах зээлийн үнэлгээ;
 - Засгийн газрын хөрөнгө оруулалтын хувьд хуулийн этгээд бүрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
- 3) Төрийн өмчийн аж ахуй нэгжийн (төрийн өмчийн ойн аж ахуй) хувьд Тусгай нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 81-р зүйлийн дагуу үнэлгээний шинэчлэл хийнэ.

Төрийн өмчийн журналыг “Төрийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем” ашиглаж эхэлснээс хойш буюу 2010 оны 1 дүгээр сараас эхлэн цахим хэлбэрээр хөтлөх болжээ.

2.7.2. Төрийн өмчийн өөрчлөлтийн тайлан

Сангийн сайд нь жил бүр “Төрийн өмчийн өөрчлөлт, өнөөгийн үнэлгээний тайлан, түүний тайлбар” болон “Хариу төлбөргүйгээр түрээслүүлсэн төрийн өмчийн тайлан, түүний тайлбар”-ыг нэгдсэн байдлаар гаргах үүргийг хүлээдэг.⁸⁷ Энэхүү тайланг дараах тухайлсан тайлангуудад үндэслэн гаргана. Үүнд:

- Яам, агентлагийн дарга нар нь өөрт харьяалагдах төрийн өмчийн хүрээнд тухайн жилийн өөрчлөлт болон өнөөгийн үнэлгээг нэгтгэх замаар боловсруулсан “Төрийн өмчийн өөрчлөлт болон өнөөгийн үнэлгээний тайлан, түүний тайлбар”;

⁸⁷ 国有財産法33条-36条。

- Төрийн өмчийн тухай хуулийн дагуу хариу төлбөргүйгээр түрээслүүлсэн хөрөнгийн жагсаалтыг тусгасан “Хариу төлбөргүй түрээслүүлсэн төрийн өмчийн тайлан, түүний тайлбар”.

Яам, агентлагийн дарга нар нь дээрх тухайлсан тайлангуудыг төрийн өмчийн нэгдсэн тайланд оруулах зорилгоор жил бүрийн 7 дугаар сард багтаан Сангийн сайдад хүргүүлнэ⁸⁸. Улмаар Сангийн сайд нь төрийн өмчийн нэгдсэн тайланг гаргаж Засгийн газарт хүргүүлнэ. Харин Засгийн газраас дараа жилийн 10 дугаар сарын 31-ний дотор Төрийн аудитад шилжүүлж, шалгалт оруулсны дараа Парламентын нээлтийн хуралд танилцуулдаг байна⁸⁹. Ингэхдээ дараах баримт бичгийг хавсаргана⁹⁰. Үүнд:

- Төрийн өмчийн хөрөнгийн өөрчлөлт болон өнөөгийн үнэлгээ, түүний тайлбар;
- Төрийн аудитын дүгнэлт.

Нэмэлт мэдээлэл:

- Төрийн өмчийн нэгдсэн тайлан нь бүх яам, агентлагийн тухайлсан тайланд үндэслэсэн байх;
- Үнэлгээний хувьд бүхэл тоогоор илэрхийлэх боломжгүй үнийн дүнг үлдээх байдлаар бичигдэх тул бодит байдлаас бага хэмжээний зөрүүтэй байх боломжтой;
- Яам, агентлагийн нэрийн хувьд яам, агентлагийн өмнөх жилд хэрэглэж байсан албан ёсны нэрийг тайланд ашиглана.

2.7.3. Төрийн өмчийн үнэлгээний талаар урьдчилсан таамаглалын тайлан

Яам, агентлагийн дарга нар нь жил бүрийн 9 дүгээр сарын 30-ны дотор тухайн болон дараа жилийн төрийн өмчийн үнэлгээний талаарх урьдчилсан таамаглалын тайланг боловсруулж Сангийн сайдад

⁸⁸ 国有財産法 33条。

⁸⁹ 国有財産法34条 - 37条。

⁹⁰ 国有財産法34条。

хүргүүлнэ⁹¹. Харин Сангийн сайд нь төрийн өмчийн талаар урьдчилсан таамаглалын тайланд үндэслэн дараа жилийн төрийн өмчийн урьдчилсан таамаглалын нэгдсэн тайланг боловсруулна.

2.7.4. Төрийн өмчийг хариу төлбөргүй түрээслүүлсэн байдлын тайлан

Яам, агентлагийн дарга нар нь тухайн санхүүгийн жилийн төгсгөлд төрийн өмчийг хариу төлбөргүй түрээслүүлсэн байдлын тайлан боловсруулж, дараа жилийн 7 дугаар сарын 31-ний дотор Сангийн сайдад хүргүүлнэ⁹². Сангийн сайд нь уг тайлангуудад үндэслэн нэгдсэн тайланг боловсруулах бөгөөд бүхий л материалыг Төрийн аудитад хүргүүлж, шалгалт оруулна.

2.7.5. Ил тод байдал

Сангийн яам болон бусад холбогдох төрийн байгууллага нь төрийн өмчийн хөрөнгийг олон нийтийн өмнө ил тод байлгах үүднээс төрийн өмчийн газартай холбоотой аливаа мэдээллээс эхлээд хуульд заасан олон төрлийн тайлан, хэвлэмэл мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Нийтэд тод болгох мэдээллийг дараах байдлаар ангилж болно (Хүснэгт 6-г харна уу).

⁹¹ 国有財産法35条1項。

⁹² 国有財産法36条1項。

⁹³ 国有財産法34条。

⁹⁴ 国有財産法37条。

⁹⁵ 財政法28条。

⁹⁶ 財政法48条。

Хүснэгт 6. Мэдээлэл, тайлан

Ангилал	Хэлбэр	Мэдээллийн агуулга	Нийтлэх хугацаа
Төрийн өмчийн өсөлт, бууралт болон нийт үнэлгээний тайлан, түүний тайлбар ⁹³	Парламент (Тайлан)	Тоо хэмжээ, журналын үнэлгээ	Жилд нэг удаа 11 дүгээр сард
Төрийн өмчийг хариу төлбөргүйгээр түрээслүүлсэн байдал, түүний тайлбар ⁹⁴	Парламент (Тайлан)	Тоо хэмжээ, журналын үнэлгээ	Жилд 1 удаа 11 дүгээр сард
Төрийн өмчийн өнөөгийн үнэлгээний тайлан ⁹⁵	Парламент (Хүргүүлэх)	Тоо хэмжээ, журналын үнэлгээ	Жилд 1 удаа 1 дүгээр сард
Төрийн өмчийн өнөөгийн үнэлгээний тайлан ⁹⁶	Төрийн мэдээлэл (Тайлан)	Тоо хэмжээ, журналын үнэлгээ	Жилд 1 удаа 4 дүгээр сард

Хүснэгт 7. Тогтмол мэдээлэл

Ангилал	Мэдээллийн агуулга	Нийтлэх хугацаа
Төсөв санхүүгийн статистик: Төрийн өмчийн тусгай дугаар	Төрийн өмчийн тогтолцоо, Төрийн өмчийн өнөөгийн үнэлгээ, өсөлт бууралт, Засгийн газрын хөрөнгө оруулалтын нөхцөл байдал, Захиргааны болон ердийн өмчийн статистик	Жилд 1 удаа 3 дугаар сард

Жил бүр Төрийн өмчийн тухай хуулийн 34 болон 37-р зүйлд заасны дагуу “төрийн өмчийн өсөлт, бууралт болон өнөөгийн үнэлгээ, түүний тайлбар”, “төрийн өмчийг хариу төлбөргүйгээр түрээслүүлсэн байдлын тайлан”-д Төрийн аудитын шалгалт хийсний дараа Парламентад тайлагнана. Мөн Төсвийн тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу төсвийн бэлтгэл материалын хүрээнд төрийн өмчийн хөрөнгийн нийт үнэлгээнд хамаарах судалгааг Парламентад хүргүүлж, түүнчлэн уг хуулийн 46-р зүйлд заасны дагуу өнөөгийн үнэлгээг иргэдэд тайлагнана.

Ямар төрлийн мэдээллийг, ямар хугацаанд иргэдэд тайлагнаж байх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 8-д харуулав.

Хүснэгт 8. Сангийн яамны вэб хуудас

Ангилал	Агуулга	Шинэчлэх хугацаа
Төрийн өмчийн тайлан	Төрийн өмчийн танилцуулга, сүүлийн үеийн удирдлага	Жилд 1 удаа 6 дугаар сард
Хяналтын хорооны хурал	Асуулт хариулт, тайлан, танилцуулга, хурлын тэмдэглэл гэх мэт	-
Төрийн өмчийн үр дүнтэй ашиглалт	Тайлан, танилцуулга, сонсгол гэх мэт	-
PRE стратеги	Тайлан, танилцуулга, сонсгол гэх мэт	-
Төрийн өмчийн тусгай дугаар	Төрийн өмчийн тогтолцоо, өнөөгийн үнэлгээ, өсөлт бууралт, Засгийн газрын хөрөнгө оруулалтын нөхцөл байдал, захиргааны болон ердийн өмчийн статистик	Жилд 1 удаа 3 дугаар сард
Яам, агентлагуудын хөрөнгийн аудит	Яам, агентлагуудын хөрөнгийн судалгаа, ашиглаагүй газрын нэгтгэл	-
Төрийн мэдээллийн булан		
Худалдаж буй төрийн өмчийн газар	Худалдаж буй төрийн өмчийн талаарх бүх мэдээлэл	-
Цаашид худалдах төрийн өмч	Цаашид худалдахаар төлөвлөж буй төрийн өмчийн талаар бүх мэдээлэл	-
Төрийн өмчийн хөрөнгө бүрийн мэдээлэл	Хөрөнгө тус бүрийн байршил, тоо хэмжээ, үнэ зэрэг	Жилд 1 удаа 12 дугаар сард

Статистик мэдээлэл	Парламентад хүргүүлсэн мэдээлэл, бүх төрлийн статистик	-
Та төрийн өмчийг мэдэх үү?	Төрийн өмчийн үндсэн мэдээлэл, худалдаж авах арга	Жилд 1 удаа 12 дугаар сард
Топикс (танилцуулга)	Бүх төрлийн танилцуулга	-
Төрийн өмчийн шуурхай мэдээ	Төрийн өмчийн талаарх шуурхай мэдээ	-

Сангийн яам нь өөрийн вэб хуудсаар (хаяг: <http://www.mof.go.jp>) “төрийн өмч” гэсэн булан үүсгэж, төрийн өмчийн хөрөнгийн талаарх сүүлийн үеийн мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэдэг.

Хүснэгт 9. Төрийн өмчийн олон нийтийн мэдээллийн сан

Төрийн өмчийн тухай мэдээлэл олж авах	Талбай, хэмжээ ба бусад мэдээлэл	Шинэчлэх хугацаа
Төрийн өмчийг “худалдаж авах”	Худалдаж буй төрийн өмч	-
Төрийн өмчийг “түрээслэх”	Түрээслэх боломжтой төрийн өмч	Захиргааны өмчийн хоосон талбай, түрээслэх боломжтой хөрөнгийн жагсаалт
Төрийн өмчийг “судлах”	Нэр бүрийн мэдээлэл	Хөрөнгө тус бүрийн байршил, тоо хэмжээ, үнэлгээ зэрэг
	Статистик	Бүх төрлийн статистик
Төрийн өмчийн талаар “мэдээлэл авах”	Та мэдэх үү? Төрийн өмчийн талаар	Төрийн өмчийн үндсэн мэдээлэл, худалдаж авах арга
	Шуурхай мэдээ	Төрийн өмчийн талаарх шуурхай мэдээ

Төрийн өмчийн олон нийтийн мэдээллийн санд (Хаяг: <http://www.kokuyuzaisan.-info.mof.go.jp/>) “Худалдаж буй төрийн өмчийн газар”, “төрийн өмчийн хөрөнгийн нэг бүрчилсэн мэдээлэл”, “Статистик мэдээлэл” (Парламентад тайлагнаж буй мэдээлэл), “Та төрийн өмчийн талаар мэдэх үү? (олон нийтэд зориулсан тараах материал)”, “Топикс” (танилцуулах илтгэл), “Төрийн өмчийн шуурхай мэдээ” зэргийг олон нийтэд мэдээлдэг байна.

“Төрийн өмчийн хөрөнгийн талаарх нэг бүрчилсэн мэдээлэл”-ийн хүрээнд тухайн хөрөнгийн байршил, тоо хэмжээ, журнал дахь үнэлгээ зэргийг тусгана. Мөн “Худалдаж буй төрийн өмчийн газар”-ын хувьд дуудлага худалдаанд оруулж буй хөрөнгө, шууд худалдах болон цаашид худалдахаар төлөвлөж буй хөрөнгийн талаарх мэдээлэл, тэдгээрийн байршил, талбай, хуулийн хязгаарлалт, зам тээврийн нөхцөл зэргийг тусгах шаардлагатай.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН ӨМЧИЙН ШААРДАХ ЭРХИЙГ УДИРДАХ ТУХАЙ ХУУЛЬ

3.1. Төрийн өмчийн шаардах эрхийн тухай ойлголт

Япон Улс нь 1955 онд Төрийн өмчийн шаардах эрхийн тухай хуулийг баталжээ. Уг хуулийн зорилго нь төрийн өмчийн шаардах эрхийг зохистой удирдлагаар хангахын тулд шаардах эрхийг хэрэгжүүлэх байгууллага болон процессыг тогтоох явдал байв. Тэрчлэн шаардах эрхийн өөрчлөлт, чөлөөлөлтөд тавих нийтлэг шаардлагыг тодорхой болгож, шаардах эрхийн үндэслэл болсон гэрээ, түүний агуулгыг зохицуулдаг байна⁹⁷. Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай хууль нь дараах бүтэцтэй. Үүнд:

- Бүлэг 1. Нийтлэг үндэслэл
- Бүлэг 2. Шаардах эрхийг удирдах этгээд
- Бүлэг 3. Шаардах эрхийг удирдах тусгай журам
- Бүлэг 4. Шаардах эрхийн өөрчлөлт, чөлөөлөлт
- Бүлэг 5. Шаардах эрхэд хамаарах гэрээний агуулга
- Бүлэг 6. Дагалдах журам.

Төрийн өмчийн шаардах эрх гэдэг нь бэлэн мөнгөний авлагыг илэрхийлэх төрийн эрх бөгөөд дараах төрийн шаардах эрхэд уг хуулийн зохицуулалт хамаардаггүй байна. Үүнд:

- Торгууль, албадан хураах зэрэг ялын шинжтэй авлага;
- Үнэт цаасны хэлбэрт шилжсэн шаардах эрх (өрийн хэрэгсэл, хувьцаанд хөрвөх үнэт цаас зэрэг);
- Хандивын мөнгөнд хамаарах шаардах эрх гэх мэт хамаарна.

⁹⁷ 国の債権の管理等に関する法律1条。

3.2. Шаардах эрхийг удирдах этгээд

3.2.1 Шаардах эрхийн нэгдсэн удирдлага

Төрийн өмчийн шаардах эрхийн нэгдсэн удирдлагыг Сангийн сайд хэрэгжүүлэх бөгөөд шаардах эрхийг удирдах тогтолцоог бий болгох, зохион байгуулах үүргийг хүлээдэг⁹⁸. Улмаар агентлагийн дарга нараас шаардах эрхийн удирдлагын тайланг шаардах, газар дээр нь шалгалт хийх болон холбогдох бусад арга хэмжээ авах бүрэн эрхтэй.

3.2.2 Шаардах эрхийн тухайлсан удирдлага

Шаардах эрхийн тухайлсан удирдлагыг яам, агентлагийн дарга нар хэрэгжүүлнэ. Мөн яам, агентлагийн дарга нар нь хууль тогтоомжид заасны дагуу тухайн байгууллагын ажилтанд шаардах эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой үйл ажиллагааг даалгаж болно⁹⁹.

3.3. Тайлагнал

Засгийн газар нь төрийн өмчийн шаардах эрхийн талаар нэгдсэн тайланг боловсруулж, жил бүр Парламентад тайлагнана. Төрийн өмчийн шаардах эрхийн тайлагнал нь дараах үе шаттайгаар явагдана. Үүнд:

- 1) Яам, агентлагийн дарга нар нь жилийн эцэст төрийн өмчийн шаардах эрхийн өнөөгийн үнэлгээг боловсруулж, дараа жилийн 7 дугаар сарын 31-ний дотор Сангийн сайдад хүргүүлнэ¹⁰⁰.
- 2) Сангийн сайд нь төрийн өмчийн шаардах эрхийн өнөөгийн үнэлгээний нэгдсэн тайланг боловсруулна. Засгийн газраас төрийн өмчийн шаардах эрхийн өнөөгийн үнэлгээг дараа жилийн 10 дугаар сарын 30-ны дотор Төрийн аудитад хүргүүлнэ.

⁹⁸ 国の債権の管理等に関する法律9条。

⁹⁹ 国の債権の管理等に関する法律5条。

¹⁰⁰ 物品管理法39条。

- 3) Засгийн газар нь төрийн өмчийн шаардах эрхийн өнөөгийн үнэлгээний тайланд үндэслэн жилийн эцсийн байдлаар тухайн жилийн орлого, зарлагын хамт Парламентад тайлагнана.

Ийнхүү төрийн өмчийн шаардах эрхийн тайлагнал нь Төрийн өмчийн тухай хууль дахь механизмын адил тодорхой үе шатыг дамжин явсаар Парламентаар хэлэлцүүлэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭД ЗҮЙЛСИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ

Япон Улс 1956 онд Эд зүйлсийн удирдлагын тухай хуулийг баталсан. Уг хууль нь Төрийн өмчийн тухай хууль дахь албаны өмчид хамаарах эд зүйлсийн удирдлагыг зохицуулсан тусгай хууль юм. Уг хууль нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл

Бүлэг 2. Эд зүйлсийг удирдах байгууллага

Бүлэг 3. Эд зүйлсийн удирдлага

Хэсэг 1. Нийтлэг үндэслэл

Хэсэг 2. Олж авах, ашиглалтад олгох

Хэсэг 3. Хадгалах

Хэсэг 4. Захиран зарцуулах

Бүлэг 4. Эд зүйлсийг удирдах ажилтны хариуцлага

Бүлэг 5. Дагалдах журам.

Төрийн байгууллага, түүний албан тушаалтан нь албаны үйл ажиллагааны хүрээнд барилга байгууламжаас эхлээд ширээ сандал гэх мэт олон төрлийн хөрөнгийг зайлшгүй ашиглах шаардлагатай. Гэвч албан өмчид хамаарах хөрөнгө нь эдийн засгийн үнэ цэнэ болон ач холбогдлын хувьд өөр хоорондоо ихээхэн ялгаатай тул тэдгээрийг удирдах харилцааг мөн ялгамжтай байдлаар зохицуулах шаардлага үүснэ. Улмаар төрийн өмчийн эд зүйлсийн харилцааг Төрийн өмчийн тухай хуулиар бус Эд зүйлсийн удирдлагын тухай хуулиар тусгайлан зохицуулжээ.

4.1. Эд зүйлсийн тухай ойлголт, түүний хүрээ

Төрийн өмчийн эд зүйлсийн удирдлагын тухай хууль нь эд зүйлийг удирдах (олж авах, хадгалах, ашиглалтад олгох), захиран зарцуулах харилцааг зохицуулах замаар эд зүйлийн зохистой, үр дүнтэй ашиглалт, удирдлагыг хэрэгжүүлэх зорилготой. Уг хуульд зааснаар “эд зүйлс” гэдэгт дор дурдсанаас бусад төрийн өмчийн хөдлөх хөрөнгө хамаарна. Үүнд:

- Бэлэн мөнгө;
- Япон банкны хадгалж буй үнэт цаас;
- Төрийн өмчийн тухай хууль дахь хөрөнгө.

Өөрөөр хэлбэл, төрийн зүгээс захиргааны чиг үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай сандал ширээ, компьютер гээд бүхий л төрлийн хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн “эд зүйлс”-д хамааруулан ойлгоно.

4.2. Эд зүйлсийн ангилал

Эд зүйлсийн ангиллын талаар Эд зүйлсийн удирдлагын тухай хуульд нарийвчлан тусгаагүй бөгөөд Засгийн газарт эрх шилжүүлсэн байна. Эд зүйлсийн ангиллыг Хүснэгт 10-т харуулав.

Хүснэгт 10. Эд зүйлсийн ангилал

Ангилал	Ангилалд хамаарах эд зүйлс
Эд зүйл	Тоног төхөөрөмж, бичгийн хэрэгсэл, бусад харьцангуй удаан хугацаанд давтан хэрэглэх боломжтой эд зүйлс. Гэвч эд зүйлийн бүрдэл хэсэг болон дагалдах хэрэгсэл, эсхүл бага үнээр олж авах боломжтой зүйлс хамаарахгүй.
Нэг удаагийн хэрэглээний эд зүйл	Бусад ангилалд хамаарахгүй эд зүйлс
Барилга, засварын эд зүйл	Барилга, засварын хангалт болон түүний явцад бий болсон мод, чулуу, төмөр, элс шороо зэрэг эд зүйлс

Үзүүлэнд зориулсан бараа, материал	Олон нийтэд үзүүлэх бараа болон дээж материал
Түр зуур ашиглах эд зүйл (<i>temporality structure</i>)	Төрийн өмчийн бус барилга, бусад зүйлс (түр хугацаанд ашигласан эд зүйлс)
Хэрэггүй болсон эд зүйл	Акталсан эд зүйлс

Эд зүйл гэж “1 жилээс илүү хугацааны давтамжтай хэрэглээг даах 50,000 иен (500\$)-ээс дээш үнэлгээ бүхий бараа”-г хэлнэ. Өмнө нь 20,000 иен (200\$)-ээс дээш гэсэн шалгуур байсан боловч энэ нь 2015 онд шинэчлэгджээ¹⁰¹.

Нэг удаагийн хэрэглээний эд зүйлд нэг удаа хэрэглэснээр ашиглалт нь дуусгавар болдог бүхий л төрлийн эд зүйл хамаарна. Харин барилга, засварын эд зүйлд төрийн зүгээс олгож буй бараа материалын хангалт болон түүний үлдэгдэл, түүний явцад бий болсон эд зүйлс ордог. Эдгээр эд зүйлийг олж авах үед төрийн өмчийн журналд бүртгэн холбогдох хэлтэст шилжүүлэх замаар ашиглалтад ордог. Мөн эд зүйл бүрт “эд зүйлсийн мэдээллийг агуулсан наалт”-ыг бэхлэх бөгөөд наалтад ерөнхий ангилал, ангилалд хамаарах эд зүйлийн төрөл, нэр, дугаар, харьяалах газрын нэр, олж авсан он сар өдөр, үнэлгээ зэрэг мэдээлэл байх ёстой¹⁰².

4.3. Эд зүйлсийг удирдах этгээд

Япон Улс нь эд зүйлсийг удирдах этгээдийг тодорхойлохдоо Төрийн өмчийн тухай хуулийн нэгэн адил эд зүйлсийн нэгдсэн удирдлага болон тухайлсан удирдлагыг бий болгожээ.

¹⁰¹ 鈴木美羽、「適正な物品管理のための事務所独自の取り組み」1頁 [https://www.cbr.mlit.go.jp/kikaku/2018kannai/pdf/wo09.pdf].

¹⁰² 鈴木美羽、「適正な物品管理のための事務所独自の取り組み」2頁 [https://www.cbr.mlit.go.jp/kikaku/2018kannai/pdf/wo09.pdf].

4.3.1. Эд зүйлсийн нэгдсэн удирдлага

Эд зүйлийн нэгдсэн удирдлагыг Сангийн сайд хэрэгжүүлнэ¹⁰³. Сангийн сайд нь эд зүйлийн зохистой удирдлагаар хангах тогтолцоог бий болгож, түүнийг нэгдсэн удирдлагаар ханган, эд зүйлийн өсөлт, бууралт болон өнөөгийн үнэлгээг тодорхой болгож, холбогдох зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

Мөн Сангийн сайд нь холбогдох яам, агентлагийн дарга нараас эд зүйлсийн тайлан шаардах, газар дээр нь шалгалт хийх, ангилал, харьяаллыг өөрчлөх болон бусад холбогдох арга хэмжээг авч болно.

4.3.2. Эд зүйлсийн тухайлсан удирдлага

Эд зүйлсийн тухайлсан удирдлагыг яам, агентлагийн дарга нар хэрэгжүүлнэ¹⁰⁴. Мөн яам, агентлагийн дарга нар нь хууль тогтоомжид заасны дагуу өөрийн ажилтанд эд зүйлсийн удирдлагын эрхийг шилжүүлж болно¹⁰⁵. Уг эрх шилжүүлэн авсан этгээдийг “аж ахуйн албаны мэргэжилтэн” (物品管理官) хэмээн нэрлэнэ. “Аж ахуйн албаны мэргэжилтэн” нь өөрийн харьяалах байгууллагын ажилтанд эд зүйлсийг олж авах, хадгалах асуудлын эрхээ шилжүүлж болно. Ийнхүү эрх шилжүүлэн авсан этгээдийг “Нярав” (物品出納菅) гэнэ. Мөн “аж ахуйн албаны мэргэжилтэн” нь шаардлагатай тохиолдолд өөрийн харьяалах байгууллагын ажилтанд эд зүйлсийг ашиглалтад өгөх эрхийг шилжүүлэн өгч болно. Уг эрхийг шилжүүлэн авсан этгээдийг “зохион байгуулагч” (物品供用菅) гэнэ.

Улмаар аж ахуйн албаны мэргэжилтэн болон бусад ажилтан нь санаатай эсхүл болгоомжгүйгээр уг хуулийг зөрчих замаар эд зүйл олж авсан, харьяалал, ангиллыг өөрчилсөн, захиран зарцуулсан, хадгалсан, бусдад ашиглуулсан болон хуульд заасны дагуу удирдлагыг хэрэгжүүлээгүйн улмаас эд зүйлийг алга болгосон, гэмтээж төрд хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлж барагдуулна¹⁰⁶.

¹⁰³ 物品管理法12条。

¹⁰⁴ 物品管理法7条。

¹⁰⁵ 物品管理法8条。

¹⁰⁶ 物品管理法31条。

4.4. Эд зүйлсийг удирдах

Эд зүйлсийг удирдах гэдэгт эд зүйлсийг олж авах, хадгалалтад өгөх, хадгалах, захиран зарцуулах харилцаа хамаарна.

Аж ахуйн албаны мэргэжилтэн нь жил бүр хариуцаж буй эд зүйлсийн үр дүнтэй ашиглалт, зарцуулалтыг сайжруулахын тулд төсөв болон үйл ажиллагааны төлөвлөгөөг харгалзан эд зүйлсийн удирдлагын төлөвлөгөөг батална¹⁰⁷. Эд зүйлсийг зөвхөн уг төлөвлөгөөнд заасны дагуу ашиглалтад өгөх, зарцуулах зарчимтай.

Эд зүйлсийн удирдлагыг хэрэгжүүлж буй аливаа ажилтан нь хуульд заасан тодорхой үүргээс гадна “хариуцлагатай байх” үүрэг хүлээнэ. Мөн төрийн өмчийн хөрөнгийг хувийн хэрэгцээнд шилжүүлэн авч болохгүй.

4.4.1. Олж авах, ашиглалтад өгөх

Эд зүйлсийг олж авах, ашиглалтад өгөх хүрээнд дараах гурван төрлийн харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- 1) Олж авах процесс (аж ахуйн албаны мэргэжилтэн нь тодорхой процессын дагуу эд зүйлсийг олж авах боломжийг холбогдох этгээдэд олгоно)¹⁰⁸;
- 2) Ашиглалтад өгөх¹⁰⁹ процесс (хэрэглээнд өгөх хөрөнгийг олж авахад шаардагдах төлбөрийг аж ахуйн албаны мэргэжилтэн хариуцан гүйцэтгэх бөгөөд төлбөрийг хийсэн тохиолдолд эд зүйлсийг хүлээн авч болох талаар зохион байгуулагчид мэдэгдэнэ)¹¹⁰;
- 3) Буцаан өгөх процесс (зохион байгуулагч нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон эсхүл засвар үйлчилгээ шаардлагатай хөрөнгийн тухай аж ахуйн албанд мэдэгдэх бөгөөд аж ахуйн албанаас зөвшөөрсөн тохиолдолд буцаан авна)¹¹¹.

¹⁰⁷ 物品管理法13条。

¹⁰⁸ 物品管理法19条。

¹⁰⁹ Хэрэглээнд оруулах。

¹¹⁰ 物品管理法20条。

¹¹¹ 物品管理法21条。

4.4.2. Хадгалах

Эд зүйлсийг төрийн байгууламж дотор хадгална. Ингэхдээ ашиглалт, зарцуулалтад бэлэн байх нөхцөлийг хангана. Харин төрийн байгууламж дотор хадгалах нь тохиромжгүй эсхүл бусад шалтгаан байгаа бол бусад байгууллагад хадгалуулж болно¹¹².

Эд зүйлсийг хадгалалтаас гаргахад аж ахуйн албаны мэргэжилтэн нь тухайн хөрөнгийн ангиллыг тодорхой заасан тушаал гаргаж, няравт хүргүүлэх бөгөөд ийнхүү тушаал гараагүй бол эд зүйлийг хадгалалтаас гаргахыг хориглоно¹¹³.

4.4.3. Захиран зарцуулах

Аж ахуй албаны мэргэжилтэн нь ашиглалтад өгөх, зарцуулах шаардлагагүй эд зүйлсийн харьяалал, зориулалтыг өөрчлөх зэргээр үр дүнтэй ашиглаж чадахгүй тохиолдолд эрх шилжүүлэн авсан этгээдийн зөвшөөрлийн үндсэн дээр тухайн эд зүйлийг “хэрэггүй зүйл”-д тооцох шийдвэр гаргаж болно¹¹⁴. Улмаар “хэрэггүй зүйл” хэмээн шийдвэрлэсэн эд зүйлсийн дотроос худалдах нь зохисгүй эсхүл худалдаад үнэ цэнэ хүрэхгүй зүйлийг актална.

Мөн дараах тохиолдолд эд зүйлсийг захиран зарцуулах боломж нээлттэй байна. Үүнд:

- Худалдах зорилготой эд зүйлс эсхүл “хэрэггүй зүйл”-д тооцогдсон бол;
- Түрээслүүлэх зорилготой эд зүйлс эсхүл түрээслүүлэх нь төрийн үйл ажиллагаанд саад болохгүй тохиолдол.

Харин хуульд зааснаас бусад тохиолдолд эд зүйлсээр хөрөнгө оруулах эсхүл хувийн эрх зүйн эрх олгож үл болно¹¹⁵.

¹¹² 物品管理法22条。

¹¹³ 物品管理法22条2項および3項。

¹¹⁴ 物品管理法27条。

¹¹⁵ 物品管理法30条。

4.5. Тайлагнал

Засгийн газар нь эд зүйлсийн өнөөгийн үнэлгээний талаар жил бүр Парламентад тайлагнах үүрэгтэй. Тайлагнах үйл явц нь дараах үе шаттай. Үүнд:

- 1) Эд зүйлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажилтан (нярав гэх мэт) эд зүйлийн журналыг хөтлөх бөгөөд шаардлагатай зүйлсийг тусгаж, хадгалах үүрэг хүлээнэ¹¹⁶. Засгийн газраас чухал хэмээн тогтоосон эд зүйлийн өнөөгийн үнэлгээний тайланг тухайн санхүүгийн жилийн эцэст яам, агентлагийн дарга нар боловсруулж, дараа жилийн 7 дугаар сарын 31-ний дотор Сангийн сайдад хүргүүлнэ¹¹⁷. Сангийн сайд нь эд зүйлсийн өөрчлөлтийн болон өнөөгийн үнэлгээний нэгдсэн тайлан бэлтгэснийг¹¹⁸ Засгийн газраас дараа жилийн 10 дугаар сарын 31-ний дотор Төрийн аудитад хүргүүлнэ.
- 2) Засгийн газар нь эд зүйлсийн өөрчлөлтийн болон өнөөгийн үнэлгээний тайланг тухайн жилийн орлого, зарлагын тайлангийн хамт Парламентад танилцуулах үүрэгтэй.

Ийнхүү эд зүйлсийн тайлагнал нь тодорхой үе шатыг дамжсаны үндсэн дээр Парламентад танилцуулагдах замаар хэрэгждэг байна.

¹¹⁶ 物品管理法36条。

¹¹⁷ 物品管理法37条。

¹¹⁸ 物品管理法28条。

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Япон Улс нь төрийн өмчийг удирдах харилцааг Төрийн өмчийн тухай, Эд зүйлсийн удирдлагын тухай, Төрийн өмчийн шаардах эрхийг удирдах тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан тусгай хууль тогтоомжоор зохицуулж байна.

Уг хууль тогтоомжид хийсэн судалгааны үр дүнг дараах байдлаар ангилж болохоор байна.

1. Төрийн өмч, түүний эрх зүйн зохицуулалт

Төрийн өмч нь олон төрлийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд хөрөнгө тус бүрийн зориулалт, онцлогоос шалтгаалан түүнийг удирдах, захиран зарцуулах зохицуулалт нь ялгаатай байдаг. Улмаар төрийн өмчийн хөрөнгийг дараах байдлаар ангилан ялгамжтайгаар зохицуулжээ. Үүнд:

- Бэлэн мөнгө;
- Төрийн өмчийн тухай хууль дахь хөрөнгө (голлох хөрөнгө);
- Эд зүйлс (зарим хөдлөх хөрөнгө);
- Шаардах эрх.

Төрийн өмчийн бэлэн мөнгийг удирдах, захиран зарцуулахад чиглэсэн бие даасан хууль байхгүй бөгөөд Төсвийн орлого, зарлагын тухай хуулиар зохицуулна. Харин төрийн өмчийн бусад үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, үнэт цаас, оюуны өмч, эд зүйлс, шаардах эрхийг бие даасан хуулиар зохицуулдаг. Мөн Төрийн өмчийн тухай хууль дахь хөрөнгийг удирдах, захиран зарцуулахад чиглэсэн тусгай харилцаануудыг олон тооны бие даасан хуулиар зохицуулж байна.

Эндээс үзэхэд төрийн өмч, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд төрийн өмчийн бүхий л хөрөнгөд нийтлэг хамаарах ерөнхий хууль болон тухайн төрлийн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах онцлогоос шалтгаалан ялгамжтайгаар зохицуулсан тусгай хуулийг үе шаттайгаар батлан гаргах нь зүйтэй байна.

2. Төрийн өмчийн тухай хууль дахь өмчийн ангилал

Төрийн өмчийг түүний удирдлага, захиран зарцуулалтын онцлогоос нь хамааран дараах байдлаар ангилдаг. Үүнд:

- Захиргааны өмч;
- Ердийн өмч.

Улмаар захиргааны өмчийн хувьд түүнийг захиран зарцуулах харилцаанд тодорхой хязгаарлалт тогтоосон байдаг. Харин ердийн өмчийн хөрөнгийн хувьд үр ашигтай байдалд илүү ач холбогдол өгч, түүнийг захиран зарцуулах харилцааг нэлээд өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч, харин ийнхүү олон хэлбэрээр захиран зарцуулахад баримтлах нийтлэг зарчмыг тодорхойлжээ.

Тэрчлэн Төрийн өмчийн тухай хууль нь захиргааны өмчид хамаарах хөрөнгийг түүний онцлогоос шалтгаалан дараах дөрвөн төрөлд хуваасан. Үүнд:

- Албаны өмч;
- Нийтийн өмч;
- Хааны гэр бүлийн өмч;
- Аж ахуйн зориулалтай өмч.

Энэхүү ангиллаас хамааран төрийн өмчийн хөрөнгийг удирдах байгууллага болон захиран зарцуулах харилцааг ялгамжтайгаар зохицуулжээ.

Мөн зарим төрлийн хөрөнгийн хувьд түүнийг удирдах, захиран зарцуулах харилцаанд хатуу шалгуур тогтоож өгчээ. Эндээс үзэхэд төрийн өмчийн хөрөнгийг зориулалтыг нь харгалзан оновчтой ангилах, тухайн ангилалд үндэслэн удирдах, захиран зарцуулах харилцааг нь ялгамжтайгаар зохицуулах нь зүйтэй байна. Түүнчлэн төрийн захиргааны өмчийг дотор нь нарийвчлан ангилан ялгах замаар түүнийг удирдах этгээд болон захиран зарцуулах харилцааны зохицуулалтыг хийх нь зүйтэй юм.

3. Төрийн өмчийн тухай хууль дахь нийтийн өмч

Төрийн өмчийн тухай хууль нь захиргааны өмчийн хүрээнд нийтийн өмч гэх ангиллыг үүсгэсэн. Энэхүү өмч нь төрийн өмчид хамаарах боловч гол горхи, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн талбай зэрэг

нийтийн зориулалтай бүхий л хөрөнгийг өөртөө агуулдаг. Нийтийн өмчийн харьяалал болон зориулалтыг өөрчлөх тохиолдолд ард түмний төлөөлөл болох Парламентаас зөвшөөрөл авах шаардлагатай.

Монгол Улсын хувьд ч гол горхи, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн талбай зэрэг нийтийн зориулалтай хөрөнгийг тусгайлан ангилж, түүнийг захиран зарцуулах асуудалд хатуу шалгуур тавих (Парламентаар хэлэлцүүлэх) замаар нийтийн өмчийн зохистой удирдлагын хангах нь оновчтой байж болох юм.

4. Төрийн өмчийг удирдах этгээд

Төрийн өмчийн тухай ерөнхий хууль тогтоомж нь нийтлэг байдлаар хэрэгжих төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг бий болгодог. Өөрөөр хэлбэл Төрийн өмчийн тухай, Эд зүйлсийн удирдлагын тухай, Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай хуулиудын дагуу Сангийн сайд төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ. Сангийн сайд нь төрийн өмчийг нэгтгэн бүртгэж хяналт тавих, Засгийн газраар дамжуулан Парламентад тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Эндээс үзэхэд төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой болгох, тухайн тогтолцоонд тулгуурлах замаар төрийн өмчийн өөрчлөлт, өнөөгийн үнэлгээний талаар Парламент хяналтаа хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь оновчтой юм.

5. Төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах

Төрийн өмчийн тухай хуулиар төрийн өмчийн удирдлага, түүнийг захиран зарцуулах харилцааг ялгамжтай зохицуулах үүднээс төрийн өмчийг захиргааны болон ердийн өмч хэмээн ангилсан. Ердийн өмчид хамаарах хөрөнгийг хуульд заасны дагуу захиран зарцуулах боломжийг нээлттэй үлдээсэн ба энэ нь төрийн өмчийг үр ашигтай удирдах үзэл санаанд суурилдаг байна. Тухайлбал, ердийн өмчийг захиран зарцуулах хүрээнд түүнийг худалдах, түрээслэх, хөрөнгө итгэмжлэх замаар эргэлтэд оруулах, шилжүүлэн олгох зэрэг олон аргыг ашиглаж болохоор зохицуулж өгчээ.

Харин захиргааны өмч нь захиргааны үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хөрөнгө тул түүнийг захиран зарцуулах харилцааг хязгаарлаж, гагцхүү ердийн өмчид шилжүүлэх замаар захиран зарцуулах үндсэн зарчмыг баримталдаг байна.

Ийнхүү төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах асуудлыг төрийн өмчийн ангилалтай уях замаар төрийн өмчийн удирдлагыг оновчтой, үр ашигтай явуулах эрх зүйн суурийг бүрдүүлж өгсөн нь манай улсын хувьд анхаарууштай туршлага байна.

6. Ердийн өмчийн хөрөнгийг захиран зарцуулах

Төрийн өмчийн тухай хууль нь захиргааны өмчийн хөрөнгийг захиран зарцуулахыг зарчмын хувьд хориглодог. Харин ердийн өмчийн хөрөнгийг захиран зарцуулах харилцааг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрч, түүний хэлбэрийг Төрийн өмчийн тусгай арга хэмжээний тухай хуулиар нарийвчлан зохицуулжээ. Төрийн өмчийн тухай хуульд зааснаар ердийн өмчийн хөрөнгийг захиран зарцуулах хүрээнд худалдах, удирдах эрхийг бусдад даалгах, шилжүүлэх, түрээслүүлэх, хариу төлбөргүйгээр түрээслүүлэх, хөрөнгө итгэмжлэх зэрэг олон төрлийн хэлбэрийг хуульчлахаас гадна тэдгээрт баримтлах суурь зарчмыг тогтоож өгснөөрөө онцлогтой.

Ингэснээр хувийн эрх зүйн харилцаанд оруулах шаардлагатай тодорхой төрлийн төрийн өмчийг чөлөөтэй захиран зарцуулах боломжийг нээж өгснөөс гадна тухайн үйл ажиллагаа нь үр ашигтай байх үндсэн нөхцөлийг бүрдүүлж чаджээ.

7. Онцлог хөрөнгийг удирдах, захиран зарцуулах

Япон Улс нь Төрийн өмчийн тухай хуулиас гадна төрийн өмчийн эд зүйлс, шаардах эрх зэрэг онцлог хөрөнгийн удирдлагыг Эд зүйлсийн удирдлагын тухай, Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай зэрэг бие даасан хуулиудаар зохицуулж байна. Энэ нь тодорхой төрлийн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах харилцаанд хамаарах тусгайлсан зохицуулалтыг бий болгосноос гадна тухайн төрлийн хөрөнгийн онцлогоос шалтгаалан түүний удирдлагыг ялгамжтайгаар хэрэгжүүлэх, хамгийн гол нь өмчийн удирдлагын зохистой байдлыг хангахад чухал байна.

8. Төрийн өмчийн бүртгэл

Төрийн бүх яам, агентлаг төрийн өмчийн журнал хөтлөх нийтлэг үүрэгтэй. Төрийн өмчийн журнал нь Төрийн өмчийн тухай хууль дахь хөрөнгө, эд зүйлс, шаардах эрхийн хүрээнд ч нэгэн адил хэрэгжинэ. Улмаар Сангийн сайд нь бүхий л яам, агентлагийн журналд суурилсан тухайлсан тайлангуудыг нэгтгэн боловсруулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулна.

9. Төрийн өмчийн тайлагнал

Яам, агентлагууд өөрт нь харьяалагдах хөрөнгийг бүртгэж, Сангийн сайдад хүргүүлнэ. Харин Сангийн сайд нь яам, агентлагийн тайланг нэгтгэх замаар “Төрийн өмчийн өнөөгийн үнэлгээний тайлан”, “Төрийн өмчийн өөрчлөлтийн тайлан”, “Төрийн өмчийг хариу төлбөргүй түрээслүүлсэн байдлын тайлан” зэргийг үе шаттайгаар тогтмол боловсруулж, Парламентад тайлагнах тогтолцоотой.

Энэ нь гүйцэтгэх эрх мэдлийн толгой байгууллага болох Засгийн газар нь төрийн өмчийн өнөөгийн нөхцөл байдлын талаар тодорхой ойлголттой болохоос гадна Парламент нь ард түмний төлөөлөл болохын хувьд төрийн өмчид хяналт тавих боломжийг олгож байна.

10. Төрийн өмчийн ил тод байдал

Төрийн өмчийн олон нийтийн мэдээллийн санг үүсгэн бий болгосноос гадна төрийн өмчийн талаарх бүхий л тайлан, статистик, хэлэлцүүлэг зэрэг мэдээллийг Сангийн яам, холбогдох төрийн байгууллагууд өөрсдийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд тогтмол нээлттэй мэдээлж байна.

Энэ нь төрийн өмчид тавих олон нийтийн хяналтыг бий болгохоос гадна төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах харилцааг илүү үр дүнтэй болгоход чухал ач холбогдолтойг онцолж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль тогтоомж

1. Төвийн тухай хууль, 1947
財政法、（1947年）
2. Төсвийн орлого, зарлагын бүртгэлийн тухай хууль, 1947
会計法、（1947年）
3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай хууль, 1947
地方自治法（1947年）。
4. Төрийн өмчийн тухай хууль тогтоомж, 1948
国有財産法、（1948年）
国有財産法施行令、（1948年）
5. Төрийн өмчийн шаардах эрхийн удирдлагын тухай хууль тогтоомж, 1955
国の債権の管理等に関する法律、（1955年）
国の債権の管理等に関する法律施行令、（1955年）
6. Эд зүйлсийн удирдлагын тухай хууль, 1956
物品管理法、（1956年）
物品管理法施行規則、（1956年）
7. Төрийн өмчийн тусгай арга хэмжээний тухай хууль, 1952
国有財産特別措置法、（1952年）
8. Газар хөдлөлтийн эсрэг тусгай арга хэмжээний тухай хууль, 1978
大規模地震対策特別措置法、（1978年）
9. Цөмийн гамшгийн эсрэг тусгай арга хэмжээний тухай хууль, 1999
原子力災害対策特別措置法、（1999年）
10. Терроризмын эсрэг тусгай арга хэмжээний тухай хууль, 2004
武力撃事態等における国民の保護のための措置に関する法律、（2004年）

Цахим материал

Парламентад хүргүүлсэн тайлан

1. Парламентад хүргүүлсэн “Төрийн өмчийн өөрчлөлтийн тайлангийн товчлол”, “Хариу төлбөргүй түрээслүүлсэн хөрөнгийн тайлангийн товчлол”: [https://www.mof.go.jp/national_property/reference/houkoku/keisansyo-zougen-gaiyo2019.pdf].
2. Парламентад хүргүүлсэн “Төрийн өмчийн өөрчлөлтийн тайлан”, “Хариу төлбөргүй түрээслүүлсэн хөрөнгийн тайлан”: [https://www.mof.go.jp/national_property/reference/houkoku/keisansyo-zougen-musyo2019.pdf].
3. Парламентад хүргүүлсэн “Төрийн өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлбар”, “Хариу төлбөргүй түрээслүүлсэн хөрөнгийн тайлангийн тайлбар”: [https://www.mof.go.jp/national_property/reference/houkoku/setsumeisyo2019.pdf].
4. Парламентад хүргүүлсэн “Төрийн өмчийн өөрчлөлтийн тайлангийн таамаглалын товчлол”, “Хариу төлбөргүй түрээслүүлсэн хөрөнгийн тайлангийн таамаглалын товчлол”: [https://www.mof.go.jp/national_property/reference/houkoku/keisansyo-zougen-gaiyo-mikomi2019.pdf].

Сангийн яамны мэдээлэл

1. Төрийн өмчийн өнөөгийн үнэлгээ [https://www.mof.go.jp/national_property/kokuyuzaisan-genzaigaku.pdf].
2. Төрийн өмчийг худалдсан талаарх мэдээлэл [https://www.mof.go.jp/national_property/summary/sellout/index.htm]
3. Төрийн өмчийн хөрөнгийн талаарх аудитын дүгнэлт [https://www.mof.go.jp/national_property/summary/result/index.html].
4. Ашиглаагүй газрын нөхцөл байдал [https://www.mof.go.jp/national_property/summary/property_audit/index.htm].

Олон нийтийн мэдээллийн сан

1. Төрийн өмчийн нэгдсэн мэдээллийн сан [<https://www.kokuyuzaisan.mof.go.jp/info/>].
2. Төрийн өмчийн оюуны өмчийн эрхийн талаарх мэдээлэл [https://www.mof.go.jp/national_property/list/patent/index.htm].
3. Засгийн газрын эзэмшлийн хувьцаа [https://www.mof.go.jp/national_property/list/stocks/kabushiki/index.htm].

4. Засгийн газрын эзэмшлийн хувьцааг худалдсан байдал [https://www.mof.go.jp/national_property/list/stocks/uridashi/index.html].

Төрийн өмчийн статистик

1. Төрийн өмчийн хөрөнгийн нэгдсэн статистик [<https://www.e-stat.go.jp/stat-search/files?page=1&layout=datalist&toukei=00350400&tstat=000001015074&cycle=8&year=20181&month=0>].

Төрийн өмчийн ил тод байдал, шуурхай мэдээ

1. Сангийн яам, Хөрөнгө санхүүгийн нэгж, төрийн өмчийн репорт [https://www.mof.go.jp/national_property/full-download-2.pdf].
2. Сангийн яам, Нэгдсэн бодлогын судалгааны газар, төрийн өмчийн тусгай дугаар [https://www.mof.go.jp/pri/publication/zaikin_geppo/hyou02.htm].
3. Сангийн яам, төрийн өмчийн талаар та мэдэх үү? [https://www.mof.go.jp/national_property/publication/panf/pamphlet_s.pdf].
4. Сангийн яам, төрийн өмчийн шуурхай мэдээлэл [https://www.mof.go.jp/national_property/publication/tsuutatsu/index.htm].